



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨБ

БАГА БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨБ

БАГА БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрх зүйн баримт бичгүүд	7
Боловсролын үнэлгээ	17

БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. I АНГИ

1.1. I ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	22
1.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин.....	23
1.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл.....	23
1.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй	24
1.2.3. Үнэлгээний нэгж 3. Хоёр ба гурван хэмжээст бүтээл	24

ХОЁРДУГААР БҮЛЭГ. II АНГИ

2.1. II ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	26
2.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин.....	27
2.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл	27
2.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй	27
2.2.3. Үнэлгээний нэгж 3. Соёлын үнэт зүйл	28
2.2.4. Үнэлгээний нэгж 4. Хоёр ба гурван хэмжээст бүтээл	28

ГУРАВДУГААР БҮЛЭГ. III АНГИ

3.1. III ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	30
3.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин.....	31
3.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл	31
3.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй.....	32
3.2.3. Үнэлгээний нэгж 3. Соёлын үнэт зүйл	32
3.2.4. Үнэлгээний нэгж 4. Хоёр ба гурван хэмжээст бүтээл	33

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IV АНГИ

4.1. IV ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	35
4.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин.....	36
4.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл	36
4.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй	36
4.2.3. Үнэлгээний нэгж 3. Соёлын үнэт зүйл	37
4.2.4. Үнэлгээний нэгж 4. Хоёр ба гурван хэмжээст бүтээл	38
4.2.5. Үнэлгээний нэгж 5. Ажил мэргэжил, амьдрах ухаан.....	39

ТАВДУГААР БҮЛЭГ. V АНГИ

5.1. V ангийн үнэлгээний нэгж, суралцахуйн үр дүн	40
5.2. Үнэлгээний нэгж тус бүрийн суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн түвшин.....	41
5.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл	41
5.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй	41
5.2.3. Үнэлгээний нэгж 3. Соёлын үнэт зүйл	42
5.2.4. Үнэлгээний нэгж 4. Хоёр ба гурван хэмжээст бүтээл.....	43
5.2.5. Үнэлгээний нэгж 5. Ажил мэргэжил, амьдрах ухаан.....	45



МЭНДЧИЛГЭЭ

**Эрхэм баян-эрдэм мэдлэгийг түгээн
дэлгэрүүлэгч эрдэмтэн багш нар аа!**

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд зохицон амьдрах хувь хүний эрэлтийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэхэд дэлхийн улс орнууд ихээхэн анхаарч, боловсролын тогтолцоогоо улам бүр боловсронгуй болгож байна.

Сургалтын хөтөлбөрт суралцагчийн суралцах чадварын хөгжил, шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт, аливаа зүйлийг судлах сонирхол, идэвх зүтгэлд гарч буй ахиц амжилтыг үнэлэхээр үнэлгээний зорилтыг тодорхойлсон бөгөөд суралцагчийн үнэлгээний журамд “үнэлгээ нь шалгуурт суурилсан” байхаар заасан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/180 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийцүүлэн боловсруулж, баталлаа.

Энэхүү шалгуур үзүүлэлт батлагдсанаар суралцагчийн ахиц амжилтыг ижил шалгуураар үнэлэх /суралцагчдын ялгаатай байдлыг тодорхойлох/, хичээлийн бэлтгэлийг чанартай хангах /ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, ээлжит хичээлийн төлөвлөлт хийх/ зэрэг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг сайжруулах, эргэх холбоотой ажиллах боломж бүрдэх юм.

Оюунлаг, чадварлаг, бүтээлч шинэ эриний “Монгол хүн” бүтээх гол цөм, тулах цэг нь болсон багш, боловсролын ажилтан та бүхэнд эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Энэхүү гарын авлагыг боловсруулахад оролцсон эрдэмтэн багш, судлаач нар болон техникийн дэмжлэг үзүүлсэн Азийн Хөгжлийн банкны “Эдийн засгийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”, Дэлхийн банкны “Бага боловсролын шинэчлэл” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Лувсанцэрэнгийн ЭНХ-АМГАЛАН

Боловсрол, шинжлэх ухааны сайд



МЭНДЧИЛГЭЭ

Боловсролын үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байгаа эрдэмтэн багш, боловсролын ажилтан, судлаачид та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Суралцагчдад хаана, ямар орчинд суралцаж байгаагаас үл хамааран ижил шалгуур, ижил арга, аргачлалаар сурлагын амжилт, ахицаа бодитой тодорхойлуулах хэрэгцээ ямагт байдаг. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг бодитой, шинжлэх ухаанчаар үнэлж дүгнэн үнэлгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд үр нөлөөтэйгээр хэрэглэх нь манай орны төдийгүй дэлхийн улс орнуудын багш нарт ч сорилт хэвээр байна.

2018 онд БСШУС-ын (хуучнаар) сайдын А/425 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д суралцагчийн үнэлгээг шалгуурт суурилсан бөгөөд суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сурлагын ахиц, амжилтыг дэмжиж, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байхаар тодорхойлсон нь дээрх хэрэгцээ, шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Үнэлгээний шалгуур нь хичээл, сургалтын үр дүнд суралцагчийн юу мэддэг, юу чаддаг, яаж хийж хэрэглэх ёстойг тодорхойлж өгсөн суралцахуй, багшлахуйн ач холбогдолтой “үнэлгээний гол хэрэгсэл” юм. Багш та үнэлгээний шалгуурыг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэснээр суралцагчийн гүйцэтгэлд тулгуурлан сурлагын амжилт, ахиц, өөрчлөлтийн талаар бодитой, үр нөлөөтэй үнэлэлт, дүгнэлт хийж тэдэнд ямар дэмжлэг, хэрхэн үзүүлэхээ тодорхойлох бүрэн боломж бүрдэнэ.

Боловсролын үнэлгээний төв нь хичээл тус бүрээр эрдэмтэн, багш, судлаачдын баг бүрдүүлэн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, судлагдахуун бүрээр үнэлгээний ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖИЙН түвшинд анх удаагаа боловсруулж та бүхний гар дээр хүргэж байна.

Үнэлгээний шалгуурыг олон улсын түвшинд боловсролын үнэлгээ, тэр дундаа суралцагчийн үнэлгээ, үнэлгээний шалгуур чиглэлээр баримталж буй онол, үзэл баримтлалд тулгуурлан өөрийн орны сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуйн онцлогийг харгалзан боловсруулсан.

Боловсролын үнэлгээний тогтолцоог сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулах эрхэм багш та бүхний үйлс нь улам өөдөө байж, боловсролын хөгжлийн төлөө сэтгэл, зүтгэл нэгдэн урагшилна гэдэгт итгэл дүүрэн байгаагаа илэрхийлье.

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Лхагвасүрэнгийн **ГАНБАТ**
Захирал

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ТУШААЛ



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 06 сарын 29-ны
өдрийн 13867 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад мөрдсүгэй.
3. Энэхүү журмыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг үнэлэхэд баримталсугай.
4. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Г.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.
5. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.
6. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Журам, загвар шинэчлэн батлах тухай” А/309 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД




Ц.ЦОГЗОЛМАА

0001553

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн
А/425 дугаар тушаалын хавсралт



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН БОЛОН
СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадварын ахиц амжилт, үр дүн, төлөвшлийг үнэлж, дүгнэх, хөндлөнгийн хяналт, чанарын үнэлгээ хийхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Суралцагчийн үнэлгээ нь сурлагын ахиц, амжилтыг үнэлж, сургалтын арга хэлбэр, зохион байгуулалтад тохируулга хийх; анги дэвших болон сургууль төгсөх шалгалт /цаашид "улсын шалгалт" гэх/ нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж, сургуулийн үйл ажиллагаа, багшийн арга зүй, ур чадварыг сайжруулах; чанарын үнэлгээ нь боловсролын чанар, үр дүнг тодорхойлж, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгоход тус тус чиглэнэ.

Хоёр. Үнэлгээнд баримтлах зарчим

2.1. Үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;

2.2. Үнэлж дүгнэх үйл ажиллагаа нь зорилготой, сургалтын хөтөлбөрт нийцсэн, суралцагчийн нас, сэтгэхүй, хөгжлийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг харгалзсан, агуулга, хэлбэр нь уян хатан, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид ойлгомжтой, нээлттэй, ил тод байх;

2.3. Анги дэвших болон улсын шалгалтын сэдэв, даалгавар нь танин мэдэхүйн түвшинд нийцсэн, тохирц, найдварыг шалгасан, нууцлалыг хадгалсан, шалгуулагчдыг хүндэтгэсэн, найдвартай байх.

Гурав. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ

3.1. Суралцагчийн үнэлгээ нь тэдний эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулахад чиглэнэ.

3.2. Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.

3.3. "Шалгуурт суурилсан үнэлгээ" нь суралцагчийн амжилтын түвшинг хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ.

3.4. Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж, батална.

3.5. Оношлох үнэлгээ нь хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилгоор хийх үнэлгээ байна. Оношлох үнэлгээг ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт, сорил, судалгаа гэх мэт хэлбэрээр хийнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.6. Явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын явцад тогтмол хийх үнэлгээ байна.

3.7. Явцын үнэлгээг хичээлийн явцад суралцагчийн суралцах үйлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, асуулт, ярилцлага, хэлэлцүүлэг, бие даах ажил, рубрик, суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ гэх мэт арга, хэлбэрээр багш хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичиг /багшийн журнал/-т стандарт бус тэмдэглэгээгээр тэмдэглэж болно.

3.8. Үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил /II улирлын төгсгөл/, хичээлийн жилийн эцэс /IV улирлын төгсгөл/-т хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.

3.9. Үр дүнгийн үнэлгээг аман болон бичгийн шалгалт, сорил, туршилт, судалгааны ажил, тайлан, төсөлт ажил, илтгэл, эссэ, бүтээл, биечлэн хийж гүйцэтгэх зэрэг хэлбэрээр хийнэ.

3.10. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэхэд I, II ангид оношлох болон явцын үнэлгээ, III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.

3.11. Үр дүнгийн үнэлгээ нь тухайн хичээл, судлагдахууны агуулгын хүрээнд дараах 8 түвшинтэй байна.

Түвшин	Үнэлгээ, хувиар	Үнэлгээний түвшний шалгуур
VIII	90-100	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, хууль зарчим, зүй тогтлыг бүрэн ойлгож, шинжлэх ухааны үг хэллэг ашиглан аливаа асуудлыг тайлбарлах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, санал гаргах түвшинд эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах ямар ч нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс оновчтой илэрхийлдэг
VII	80-89	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль, зүй тогтол, хоорондын хамаарлыг ойлгож эзэмшсэн - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил бус нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгодог - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ оновчтой илэрхийлдэг
VI	70-79	- Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль зүй тогтлыг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах үйлийг зааврын дагуу төлөвлөдөг - Асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг боловсруулах тохирох аргыг сонгон хэрэглэдэг - Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг
V	60-69	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчим, хуулийг ойлгосон - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо шинэ нөхцөлд зааврын дагуу хэрэглэдэг - Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах, төлөвлөхөд оролцдог - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах тохирох аргыг сонгодог. - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, гол санааг илэрхийлдэг
IV	50-59	- Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг бүрэн ойлгосон. - Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нөхцөлд хэрэглэдэг - Асуулт асуух, асуудал таамаглал дэвшүүлж, шинжлэн судлах үйлд оролцдог. - Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах аргыг сонгон хэрэглэхийг хичээдэг. - Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, санал бодлоо энгийн байдлаар илэрхийлдэг

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ**

III	40-49	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг ойлгох, тайлбарлах түвшинд эзэмшсэн • Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил, хялбар нөхцөлд хэрэглэдэг • Бусдын дэмжлэгтэй, зааврын дагуу хялбар асуудлыг шийдвэрлэдэг • Асуулт асууж, таамаглал дэвшүүлдэг
II	30-39	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх, цээжлэх түвшинд эзэмшсэн • Эзэмшсэн мэдлэг ойлголтоо заавар, аргачлалын дагуу ашигладаг
I	0-29	• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх түвшинд эзэмшсэн

3.12. I-II ангид суралцагчийн тухайн хичээлийн жилд хүрсэн үр дүнг явцын үнэлгээнд үндэслэн анги удирдсан багш дүгнэн хувийн хэрэгт бичиж, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

3.13. III-XII ангийн суралцагчийг бүлэг сэдвийн төгсгөлд, хичээлийн жилийн II, IV улирлын эцэст тус тус багш үнэлнэ. Энэхүү үнэлгээний үр дүн /хувь/-г ангийн журналд тэмдэглэнэ. IV улирлын эцэст хийсэн үнэлгээ /хувь/ нь жилийн эцсийн дүн байна.

3.14. III-XII ангийн жилийн эцсийн дүн болон анги дэвших, улсын шалгалтын дүнг ангийн журнал, суралцагчийн хувийн хэрэгт анги удирдсан багш тус тус тэмдэглэнэ.

3.15. Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна.

3.16. Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ.

3.17. Ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага багшид зөвлөн туслах зорилгоор суралцагчийн мэдлэг, чадварын түвшинд хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийж болно. Энэхүү үнэлгээ, хяналт-шинжилгээ нь тухайн байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

3.18. Суралцагчийн төлөвшилийг хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажилд оролцсон байдал, идэвх санаачилгын талаарх хичээл заадаг болон анги удирдсан багшийн тэмдэглэл, баримт нотолгоонд үндэслэн дараах чиглэлээр дүгнэж, суралцагчийн хувийн хэрэгт бичнэ.

- санал бодлоо илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, зөрчил, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх байдал;
- бие даан сурах арга барил, бусадтай хамтран ажиллах;
- шинжлэн судлах хүсэл эрмэлзэл, сонирхол, оролцоо;
- соёл, уламжлалаа дээдлэх, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч, ажил хэрэгч байдал;
- хувийн болон орчны эрүүл ахуй, аюулгүй амьдрах, байгальтай харьцах, хамгаалах, нийгмийн харилцаанд оролцох хандлагад гарч буй өөрчлөлт;
- шинэ орчин, харилцаанд дасан зохицох чадварт гарч буй өөрчлөлт.

3.19. Анги удирдсан багш суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийн үнэлгээний талаарх дүгнэлт, саналыг хичээлийн жилийн II, IV улирлын эцэст эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.20. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний мэдээлэл нууцлалтай байх бөгөөд энэхүү мэдээлэлтэй багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч цахим болон бусад хэлбэрээр танилцах боломжийг сургууль бүрдүүлнэ.

Дөрөв. Анги дэвших шалгалт, түүний зохион байгуулалт

4.1. Анги дэвших шалгалт нь суралцагчийн мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшинг тогтооход чиглэнэ.

4.2. Сургууль нь энэхүү журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуурын дагуу дараах чиглэлээр журмын 3.9-д заасан хэлбэрээс сонгож анги дэвших шалгалтыг зохион байгуулна.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын чиглэл
Бага боловсрол	III	1	Нэгдмэл агуулга /III ангийн хөтөлбөрийн агуулгаар/
	IV	2	- Сургууль сонгох 1 хичээл - Нэгдмэл агуулга /шалгалттай хичээлээс бусад/
Суурь боловсрол	VI	2	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл
	VII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сургууль сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
	VIII	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/
Бүрэн дунд боловсрол	X	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Суралцагч сонгох 1 хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/
	XI	3	- Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ - Математик - Сонгох хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгэм судлал, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/

4.4. Журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуур болон “Анги дэвших шалгалтын бюпринт” /цаашид бюпринт гэх/, шалгалт зохион байгуулах нэгдсэн удирдамж, шалгалтын үр дүнд шинжилгээ хийх маягт, зөвлөмжийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор ерөнхий боловсролын сургуульд хүргүүлнэ.

4.5. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь ерөнхий боловсролын сургуулийн анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн “Даалгаврын нээлттэй сан” бүрдүүлж, өмчийн бүх хэлбэрийн сургуульд хүргэх, түүнийг хэрэглэх арга зүйгээр хангах ажлыг хичээлийн жилийн турш зохион байгуулна.

4.6. Анги дэвших болон улсын шалгалт зохион байгуулах ажлыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон “Шалгалтын комисс” зохион байгуулна. Комиссын дарга нь сургуулийн захирал байх бөгөөд сургалтын менежер, багш, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулна. Комиссын гишүүн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл шалгалтын сэдэв, даалгавар боловсруулахад оролцохгүй.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

4.7. Энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.7.1. анги дэвших шалгалт зохион байгуулах удирдамж, дэг боловсруулж, хэрэгжүүлэх;

4.7.2. анги дэвших шалгалттай холбогдон гарсан аливаа гомдол, маргааныг эцэслэн шийдвэрлэх;

4.7.3. шалгалтын үнэлгээ, дүн мэдээг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагаас өгсөн зөвлөмж, маягтын дагуу нэгтгэн, шалгалт зохион байгуулж дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдамжаар хангах, хяналт тавих.

4.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын үр дүнд шинжилгээ хийж, сургууль бүрд зөвлөмж боловсруулж, жил бүрийн 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

4.9. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын дүнд үндэслэн зөвлөн туслах ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.10. Сургууль энэхүү журмын 4.8-д заасан зөвлөмжид үндэслэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөн явуулна.

Тав. Улсын шалгалт, түүний зохион байгуулалт

5.1. Улсын шалгалт нь бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сурлагын амжилтад хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийхэд чиглэнэ.

5.2. Улсын шалгалтын үр дүн нь бага, дунд боловсролын сургалтын үр ашиг тооцох, сурлагын амжилтыг сайжруулах суурь мэдээлэл болно.

5.3. Бага, суурь бүрэн дунд боловсролын түвшний төгсөх ангийн суралцагч дараах хичээлээр улсын шалгалт өгнө.

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын агуулга
Бага боловсрол	V	3	1. Монгол хэл 2. Математик 3. Хүн ба байгаль
Суурь Боловсрол	IX	4	1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт: /суралцагч аль нэгийг сонгоно./ • Байгалийн ухааны нэгдмэл агуулга • Нийгмийн ухаан, түүх /нэгдмэл агуулга/ 4. Гадаадхэл /англи хэл, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/
Бүрэн дунд боловсрол	XII	4	1. Монголхэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/ 2. Математик 3. Сонгох шалгалт /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх аль нэгийг сонгоно/ 4. Гадаад хэл /англи, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/

5.4. Улсын шалгалтын товыг боловсролын үнэлгээний байгууллагаас жил бүр тогтоох бөгөөд шалгалтыг улсын хэмжээнд зэрэг эхлүүлж, дуусгана.

5.5. Улсын шалгалтын үнэлгээг энэхүү журмын 3.11-д заасан үнэлгээгээр үнэлнэ.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

5.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь "Улсын шалгалтын бюпринт" /цаашид бюпринт" гэх/, шалгалтын сэдэв боловсруулах, дүгнэх зөвлөмжийг жил бүрийн 5 дугаар сарын 15- ны өдрийн дотор баталгаажуулж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

5.8.Боловсролын үнэлгээний байгууллага нь бага, суурь, бүрэн дунд боловсролын анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн "Даалгаврын нээлттэй сан" /цаашид "даалгаврын сан" гэх/ бүрдүүлэх, шинэчлэх, баяжуулалт хийх ажлыг хариуцна.

5.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь "Улсын шалгалтын комисс"- ыг жил бүрийн 5 дугаар сарын 01 -ний өдрийн дотор байгуулна. Энэхүү комисс нь тухайн орон нутагт улсын шалгалт зохион байгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

5.10. Сургууль дээр улсын шалгалт зохион байгуулахтай холбогдуулан энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.10.1.улсын шалгалтын удирдамж, дэгийг боловсруулж, шалгалтыг зохион байгуулах;

5.10.2.шалгалт эхлэхээс 1 өдрийн өмнө энэхүү журмын 5.7-д заасан бюпринт, зөвлөмжийн дагуу улсын шалгалтын сэдэв боловсруулж, нууцлалыг хариуцах;

5.10.3.шалгалтын дүн мэдээг боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавих;

5.10.4.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч шалгалт өгөх тохиолдолд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон шалгалтын орчин бүрдүүлэх;

5.10.5.улсын шалгалттай холбогдон гарсан аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэх;

5.10.6.шалгалтын материал, тайланг сургуулийн архивт хүлээлгэн өгөх.

5.11.Шалгалт зохион байгуулах хугацаанд улсын болон олон улсын уралдаан, тэмцээнд оролцсон суралцагчийн улсын шалгалтын үнэлгээг нотлох баримтад үндэслэн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

5.12.Суралцагч өвчлөх, ар гэрийн гачигдал тохиолдох болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас шалгалт өгөөгүй эсвэл дутуу өгсөн тохиолдолд улсын шалгалтын үнэлгээг жилийн эцсийн үнэлгээгээр тооцож болно.

5.13.Боловсролын үнэлгээний байгууллага нь боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан улсын шалгалтын дүнд шинжилгээ хийж, жил бүрийн 10 дугаар сард багтаан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ.

5.14.Журмын 5.9-д заасан "Улсын шалгалтын комисс" нь улсын шалгалт зохион байгуулсан тайланг нэгтгэн, шалгалт дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Чанарын үнэлгээ, түүний зохион байгуулалт

6.1.Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.

6.2.Чанарын үнэлгээг боловсролын үнэлгээний байгууллага зохион байгуулна.

6.3.Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна.

6.4.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээ зохион байгуулах товыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтооно.

6.5.Чанарын үнэлгээг зохион байгуулах агуулгын хүрээ, шалгуурыг боловсролын үнэлгээний байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага хамтран жил бүрийн 01 дүгээр сард багтаан тогтооно.

6.6.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулах удирдамж, аргачлалыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

6.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээний өгөгдлийн сан үүсгэх, дүн шинжилгээ хийж, тайлан, санал, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.8.Чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн энэхүү журмын 6.7-д заасан байгууллага бодлого боловсруулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.

6.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага чанарын үнэлгээний тайланд үндэслэн сурлагын амжилтыг сайжруулах төлөвлөгөө гаргаж ажиллана.

6.10.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.

Долоо. Бусад

7.1.Аливаа төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх, шалгалт зохион байгуулахыг хориглоно.

---оОо---

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН А/180 ТУШААЛ



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/180

Улаанбаатар хот

Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/425 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хавсралтаар баталсугай.

2. Суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг энэхүү тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур"-ыг баримтлан 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн үнэлсүгэй.

3. Шалгуурын дагуу үнэлгээ хийх арга зүйн зөвлөмжийг боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтныг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатарт даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142110643

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ (*Student assessment*)

Сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц;

ШАЛГУУР (*Criteria*)

Зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт эсвэл түвшин;
(UNESCO-CEPES, 2007)

ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР (*Assessment criteria*)

Суралцахуйн үр дүнд хүрэхэд шаардлагатай тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлдог.

ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ (*Diagnostic assessment*)

Хичээл, сургалтын эхэнд суралцагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг тандах зорилгоор хийгдэх үнэлгээ;

ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ (*Formative assessment*)

Багш, суралцагчийн зүгээс суралцагчийн “суралцахуй”-г танин мэдэх, хариу үйлдэл үзүүлэх зорилгоор сургалтын явц /ээлжит хичээл/-д хийгдэх үнэлгээ;

ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ (*Summative assessment*)

Хичээл, сургалт /нэгж, хагас жил, жилийн эцэст г.м тодорхой хугацааны/-ын дараа үнэлгээний шалгуурт хүрсэн байдлыг тогтоож, цаашид суралцахуй болон багшлахуйд анхаарах зүйлийг тодорхойлох зорилгоор хийгдэх үнэлгээ;

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшилийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ “шалгуур”-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд “үнэлгээ”-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

1 Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

2 Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариултыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

3 Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс" судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Нэгдүгээр бүлэг - I анги
Хоёрдугаар бүлэг - II анги
Гуравдугаар бүлэг - III анги
Дөрөвдүгээр бүлэг - IV анги
Тавдугаар бүлэг - V анги

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. I АНГИ

1.1. I АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	1.1а. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг таньж хэрэглээг тодорхойлох 1.1б. Тосон харандаагаар ажиллах арга барилыг зураг дүрслэлд хэрэглэх 1.1е. Усан будгаар ажиллах арга барилыг зураг бүтээлдээ хэрэглэх	Дүрслэлийн хэл	ДУТ1.1 ҮД1. Сурагч бүтээлийн онцлогт нийцүүлж зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг (харандаа, тосон харандаа, бийр, усан будаг) сонгож хэрэглэж чаддаг болно.
	1.1в. Энгийн хэлбэр дүрс зурахдаа цэглэх, толболох, цэгүүдийг холбох аргыг ашиглах 1.1г. Энгийн дүрсээс бүтсэн эд юмсыг дүрслэхдээ шулуун, долгион, нуман, тахир зураасыг хэрэглэх 1.1д. Үндсэн 5 дүрсийн нийлэмжийг эд юмсыг дүрслэхдээ ашиглах 1.1ж. Нэг ба олон өнгөөр зурсан зургийн ялгааг харьцуулах, зураг дүрслэлдээ ашиглах		ДУТ1.1 ҮД2. Сурагч зохиомжийн хэрэгслүүд (үндсэн өнгө, цэг, толбо, зураас /шулуун долгион, нуман, тахир/, үндсэн дүрс)-ийг ялган таньж нэрлэх, зурж дүрсэлж чаддаг болно.
2	1.1з. Өөрийн бодол төсөөллөөр зурсан зургаас гол ба туслах дүрийг таньж тодорхойлох 1.1и. Өөрийн бодол төсөөллөөр зурсан зургаас наана цаана байгаа зүйлсийг таньж тодорхойлох	Урлан бүтээхүй	ДУТ1.1 ҮД3. Сурагч өөрийн бодол төсөөллөөр зураг зурахдаа гол зүйлийг нь наана, туслах зүйлийг нь цаана байрлуулан дүрсэлж чаддаг болно.
3	1.2а. Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэх, өрөх аргаар бүтээх 1.2б. Үндсэн дүрсийг зохиомжлон наах аргаар бүтээл хийх 1.2в. Үндсэн дүрсийг эвлүүлж наах аргыг техникийн загвар бүтээхэд хэрэглэх 1.2е. Навч өрж наах аргаар амьтны дүрс бүтээх	Хоёр ба гурван хэмжээст бүтээл	ДУТ1.2 ҮД4. Сурагч үндсэн дүрс болон байгалийн материал (навч)-ыг хайчлах, эвлүүлэн өрж наах аргаар 2 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.
	1.2г. Амьтны ба техникийн загвар бүтээхдээ цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж хайчлах аргыг ашиглах 1.2д. Цаасыг нугалах аргаар бүтээл хийх бүтээх		ДУТ1.2 ҮД5. Сурагч цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж хайчлах аргаар техникийн загвар, зааврын дагуу нугалж 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.
	1.2ж. Баримлын шавартай ажиллах хэрэглэгдэхүүнийг таньж зориулалтыг тодорхойлох 1.2з. Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх аргаар хагас товгор дүрс бүтээх 1.2и. Баримлын шаврыг цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох, мушгих аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний загвар хийх		ДУТ1.2 ҮД6. Сурагч баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх, цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох аргаар 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.

1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

1.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ1.1 ҮД1. Сурагч бүтээлийн онцлогт нийцүүлж зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг (харандаа, тосон харандаа, бийр, усан будаг) сонгож хэрэглэж чаддаг болно.	ДУТ1.1 ҮД1 Ш1. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг (харандаа, тосон харандаа, бийр, усан будаг) нэрлэх, хэрэглээг тайлбарладаг.
		ДУТ1.1 ҮД1 Ш2. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг (тосон харандаа, бийр, усан будаг) бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгож хэрэглэдэг.
2	ДУТ1.1 ҮД2. Сурагч зохиомжийн хэрэгслүүд (үндсэн өнгө, цэг, толбо, зураас /шулуун долгион, нуман, тахир/, үндсэн дүрс)-ийг ялган таньж нэрлэх, зурж дүрсэлж чаддаг болно.	ДУТ1.1 ҮД2 Ш3. Цэг, толбыг ялган таньж зураг дүрслэлдээ ашигладаг.
		ДУТ1.1 ҮД2 Ш4. Зураас (шулуун, долгион, нуман, тахир)-ыг ялган таньж зураг дүрслэлдээ ашигладаг.
		ДУТ1.1 ҮД2 Ш5. Үндсэн 5 дүрсийг ялган таньж эд юмсыг дүрслэхдээ ашигладаг.
		ДУТ1.1 ҮД2 Ш6. Нэг ба олон өнгийн ялгааг зураг дүрслэлдээ ашигладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	I	II	III
ДУТ1.1 ҮД1 Ш1. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг (харандаа, тосон харандаа, бийр, усан будаг) нэрлэх, хэрэглээг тайлбарладаг.	Зургийн багаж, хэрэглэгдэхүүн (харандаа, баллуур, шохойн болон тосон харандаа, бийр, усан будаг)-ийг таньж нэрлэдэг.	Зургийн багаж, хэрэглэгдэхүүн (харандаа, шохойн болон тосон харандаа, бийр)-ийг зөв барьж харуулдаг.	Зургийн багаж, хэрэглэгдэхүүн (харандаа, баллуур, шохойн болон тосон харандаа, бийр, усан будаг)-ийг хэрэглээг жишээгээр тайлбарладаг.
ДУТ1.1 ҮД1 Ш2. Зургийн багаж, хэрэглэгдэхүүнийг (тосон харандаа, бийр, усан будаг) бүтээлийн онцлогт нийцүүлэн сонгож хэрэглэдэг.	Сонгосон дүрс, дүрслэлийг харандаагаа сонгож зурдаг.	Сонгосон дүрс, дүрслэлийг шохойн болон тосон харандаагаар зурж, буддаг.	Сонгосон дүрс, дүрслэлийг бийрээ зөв барьж, усан будгаар жигд буддаг.
ДУТ1.1 ҮД2 Ш3. Цэг, толбыг ялган таньж зураг дүрслэлдээ ашигладаг.	Цэг, толбыг ялган таньж нэрлэдэг.	Цэг, толбыг ялган дүрсэлдэг.	Цэг, толбоор зураг зурж дүрсэлдэг.
ДУТ1.1 ҮД2 Ш4. Зураас (шулуун, долгион, нуман, тахир)-ыг ялган таньж зураг дүрслэлдээ ашигладаг.	Зураг дүрслэлээс аль нь шулуун, долгион, нуман, тахир зураас болохыг ялган таньж нэрлэдэг.	Цэгүүдийг хооронд нь холбон зурах аргаар шулуун, долгион, нуман, тахир зураас зурдаг.	Уул, тал, мод, байшин, ус зэргээс сонгон шулуун, долгион, нуман, тахир зураас ашиглан зурж буддаг.
ДУТ1.1 ҮД2 Ш5. Үндсэн 5 дүрсийг ялган таньж эд юмсыг дүрслэхдээ ашигладаг.	Үндсэн 5 дүрсийг ялган таньж нэрлэдэг.	Үндсэн 5 дүрсийг хэв ашиглан зурж дүрсэлдэг.	Үндсэн 5 дүрсийг зохиомжлон эд юмсыг дүрсэлж, тосон харандаагаар буддаг.
ДУТ1.1 ҮД2 Ш6. Нэг ба олон өнгийн ялгааг зураг дүрслэлдээ ашигладаг.	Хүүхдийн зургийн бүтээлээс нэг ба олон өнгийг ялган таньж нэрлэдэг.	3-аас дээш төрлийн зүйлс (хүнсний ногоо) зурж нэг өнгөөр ялган буддаг.	Байгалийн үзэгдэл, ургамлын дүрсийг зурж нэг өнгөөр ялган буддаг.

1.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ1.1 ҮД3. Сурагч өөрийн бодол төсөөллөөр зураг зурахдаа гол зүйлийг нь наана, туслах зүйлийг нь цаана байрлуулан дүрсэлж чаддаг болно.	ДУТ1.1 ҮД3 Ш7. Өөрийн бодол төсөөллөөр зураг зурахдаа гол ба туслах зүйлийг ялган дүрсэлдэг.
		ДУТ1.1 ҮД3 Ш8. Өөрийн бодол төсөөллөөр зураг зурахдаа наана цаана байгаа зүйлсийг тодорхойлж дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	I	II	III
ДУТ1.1 ҮД3 Ш7. Өөрийн бодол төсөөллөөр зураг зурахдаа гол ба туслах зүйлийг ялган дүрсэлдэг.	Хүүхдийн зургийн бүтээлээс гол ба туслах дүрийг нэрлэдэг.	Зургаас гол ба туслах дүрийн ялгааг тайлбарладаг.	Өөрийн бодол төсөөллөөр зураг зурахдаа гол зүйлийг наана, туслах зүйлийг цаана дүрсэлдэг.
ДУТ1.1 ҮД3 Ш8. Өөрийн бодол төсөөллөөр зураг зурахдаа наана цаана байгаа зүйлсийг тодорхойлж дүрсэлдэг.	Хүүхдийн зургийн бүтээлээс наана цаана байгаа зүйлсийг нэрлэдэг.	Зургаас наана цаана байгаа зүйлсийг ялгааг тайлбарладаг.	Өөрийн бодол төсөөллөөр зураг зурахдаа гол зүйлийг наана, туслах зүйлийг цаана дүрсэлдэг.

1.2.3. Үнэлгээний нэгж 3. Хоёр ба гурван хэмжээст бүтээл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ1.2 ҮД4. Сурагч үндсэн дүрс болон байгалийн материал (навч)-ыг хайчлах, эвлүүлэн өрж наах аргаар 2 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.	ДУТ1.2 ҮД4 Ш9. Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэн өрж наах аргаар 2 хэмжээст бүтээл хийдэг.
		ДУТ1.2 ҮД4 Ш10. Байгалийн материал (навч)-ыг өрж наах аргаар амьтны дүрс бүтээдэг.
2	ДУТ1.2 ҮД5. Сурагч цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж хайчлах аргаар техникийн загвар, зааврын дагуу нугалж 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.	ДУТ1.2 ҮД5 Ш11. Техникийн загварыг цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж, хайчлах аргаар бүтээдэг.
		ДУТ1.2 ҮД5 Ш12. Цаасыг зааврын дагуу 2-3 нугалж бүтээл хийдэг.
3	ДУТ1.2 ҮД6. Сурагч баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх, цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох аргаар 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.	ДУТ1.2 ҮД6 Ш13. Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх, цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний загвар хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	I	II	III
ДУТ1.2 ҮД4 Ш9. Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэн өрж наах аргаар 2 хэмжээст бүтээл хийдэг.	Үндсэн дүрсийг зурж хайчилдаг.	Үндсэн дүрсээ өрж эвлүүлж дүрс бүтээдэг.	Үндсэн дүрсээ зохиомжлон нааж 2 хэмжээст бүтээл хийдэг.
ДУТ1.2 ҮД4 Ш10. Байгалийн материал (навч)-ыг өрж наах аргаар амьтны дүрс бүтээдэг.	Навчны гадаад хэлбэрийг ажиглан ямар амьтан бүтээхээ тодорхойлж тайлбарладаг.	Навчаар амьтны дүрс бүтээдэг.	Навчийг өрж наах аргаар амьтны дүрс үүсгэн бүтээл хийдэг.
ДУТ1.2 ҮД5 Ш11. Техникийн загварыг цаасыг тэнцүү хэсэг болгон нугалж, хайчлах аргаар бүтээдэг.	Ам дөрвөлжин цаасыг тэнцүү хэсэг болгон нугалдаг.	Нугалсан цаасны битүү хэсэгт техникийн загварыг хэв ашиглан зурдаг.	Зураасны дагуу хайчилж техникийн загвар бүтээдэг.
ДУТ1.2 ҮД5 Ш12. Цаасыг зааврын дагуу 2-3 нугалж бүтээл хийдэг.	Ам дөрвөлжин цаасыг 2-3 нугалж бүтээл хийх зурган зааврыг тайлбарладаг.	Зурган зааврын дагуу цаасыг 1-2 нугалах алхмыг зөв гүйцэтгэдэг.	Зурган зааврын дагуу алхмуудыг зөв гүйцэтгэж бүтээл хийдэг.
ДУТ1.2 ҮД6 Ш13. Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх, цувих, хэрчих, бөөрөнхийлөх, холбох аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний загвар хийдэг.	Баримлын шавартай ажиллах хэрэглэгдэхүүнийг таньж нэрлэх, зориулалтыг тайлбарладаг.	Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх, цувих, хэрчих, бөөрөнхийлөх аргаар хүнсний ногоо, жимс жимсгэний бүрдэл хэсгийг хийдэг.	Бүрдэл хэсгийг холбон хүнсний ногоо, жимс жимсгэний загвар бүтээдэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. II АНГИ

2.1. II АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	2.1а. Үндсэн өнгийг хольж, үүсмэл өнгүүдийг үүсгэх замаар үндсэн болон үүсмэл өнгийг ялгааг таньж тодорхойлох 2.1б. Үндсэн болон үүсмэл өнгийг зураг дүрслэлдээ ашиглах 2.1в. Хуруугаар дардаслах аргаар толбо үүсгэн өөрийн бодол төсөөллөөр баяжуулан зурах 2.1г. Ургамал, амьтан дүрслэхдээ махир зураасыг хэрэглэх 2.1д. Эд юмсыг зурахдаа үндсэн 5 дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөх аргыг ашиглах	Дүрслэлийн хэл	ДУТ2.1 ҮД1. Сурагч зохиомжийн хэрэгслүүдийн (үүсмэл өнгө, толбо, махир зураас, дүрс) ялгааг таньж тодорхойлох, зураг бүтээлдээ ашигладаг болно.
2	2.1е. Уншсан зүйлийнхээ агуулгаар зурсан зургаас гол ба туслах дүрийн ялгааг тайлбарлах 2.1ж. Давхцуулан зурах аргаар юмсын наана, цаана хол, ойр байршлыг дүрслэн харуулах	Урлан бүтээхүй	ДУТ2.1 ҮД2. Сурагч зураг зурахдаа уншсан зүйлийнхээ гол ба туслах дүрийн ялгааг тодорхойлж, наана цаана хол ойр байршлыг давхцуулан зурах аргаар дүрсэлж чаддаг болно.
3	2.1з. Хоёр өнгөөр дагнааслан будах аргаар цэцэг, навчин хээг дүрслэх 2.1и. Чулуун дээр зураас арилгагч (штрих), шохойн ба лааны тосон харандаагаар зураг зурах аргыг хэрэглэх	Соёлын үнэт зүйл	ДУТ2.1 ҮД3. Сурагч уламжлалт зураг дүрслэлийн талаарх ойлголтоо чулуун дээр зурах болон 2 өнгийг дагнааслах аргаар дүрсэлж чаддаг болно.
4	2.2а. Үндсэн дүрсээр нийлмэл дүрс бүтээж харьцуулан тайлбарлах 2.2г. Үндсэн болон нийлмэл дүрсийг эвлүүлж наах аргаар техникийн загвар бүтээх 2.2з. Өвс ургамал, навчаар 2 хэмжээст бүтээл хийх 2.2д. Олон дүрс ашиглаж, эвлүүлдэг тоглоом зохион бүтээх 2.2г. Үндсэн болон нийлмэл дүрсийг эвлүүлж наах аргаар техникийн загвар бүтээх 2.2б. Ам дөрвөлжин цаасан нугалаагаар амьтны дүрс бүтээх 2.2в. Цаасыг хуйлах, тэнийлгэх аргаар бэлэг дурсгалын бүтээл хийх 2.2е. Ургамал, амьтны дүрс бүтээхэд баримлын шаврыг цаасан дээр нялж наах аргыг ашиглах 2.2ж. Баримлын шавар, савх модыг холбох аргаар мал, амьтны загвар хийх, бүрдэл хэсгийг нэрлэх 2.2и. Өнгө өнгийн чулууг баримлын шавраар холбох аргаар амьтны баримал хийх 2.2к. Номын хавчуурга хийхэд төрөл бүрийн материалыг ашиглах 2.2л. Шувууны тэжээл бэлтгэхэд цаасан хайрцаг ашиглах	Хоёр ба гурван хэмжээст бүтээл	ДУТ2.2 ҮД4. Сурагч үндсэн дүрсээр нийлмэл дүрс үүсгэх болон байгалийн материал (өвс ургамал, навчаар)-ыг өрж эвлүүлэх аргаар 2 хэмжээст бүтээл хийж чаддаг болно. ДУТ2.2 ҮД5. Сурагч цаасыг зааврын дагуу нугалах болон хуйлах, тэнийлгэх аргаар 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно. ДУТ2.2 ҮД6. Сурагч баримлын шавар болон бусад материалыг хослуулан 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно. ДУТ2.2 ҮД7. Сурагч төрөл бүрийн материалыг ашиглан хэрэгцээт зүйлс хийдэг болно.

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

2.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ2.1 ҮД1. Сурагч зохиомжийн хэрэгслүүдийн (үүсмэл өнгө, толбо, махир зураас, дүрс) ялгааг таньж тодорхойлох, зураг бүтээлдээ ашигладаг болно.	ДУТ2.1 ҮД1 Ш1. Үндсэн болон үүсмэл өнгийг ялган таних, үндсэн өнгөөс үүсэл өнгө үүсгэн зурж дүрсэлдэг.
		ДУТ2.1 ҮД1 Ш2. Хуруугаар дардаслан толбо үүсгэх аргаар дүрс бүтээдэг.
		ДУТ2.1 ҮД1 Ш3. Махир зураасыг ялган таньж ургамал, амьтан дүрсэлдэг.
		ДУТ2.1 ҮД1 Ш4. Үндсэн 5 дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөх аргаар эд юмсыг зурж дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	I	II	III
ДУТ2.1 ҮД1 Ш1. Үндсэн болон үүсмэл өнгийг ялган таних, үндсэн өнгөөс үүсэл өнгө үүсгэн зурж дүрсэлдэг.	Үндсэн болон үүсмэл өнгийг ялган таньж нэрлэдэг.	Үндсэн өнгийг хооронд хольж үүсмэл өнгө үүсгэдэг.	Сэдвийн хүрээнд үндсэн болон үүсмэл өнгөөр зурж дүрсэлдэг.
ДУТ2.1 ҮД1 Ш2. Хуруугаар дардаслан толбо үүсгэх аргаар дүрс бүтээдэг.	Хурууны өндгөнд будаг түрхэж, дардаслан толбо үүсгэдэг.	Хуруугаар дардаслан хэлбэр хэмжээгээрээ ялгаатай янз бүрийн толбо үүсгэн дүрс бүтээдэг.	Хуруугаар дардасласан толбыг нэмэлт зураасаар баяжуулан зурж бүтээл хийдэг.
ДУТ2.1 ҮД1 Ш3. Махир зураасыг ялган таньж ургамал, амьтан дүрсэлдэг.	Цэг холбон махир зураасыг босоо, ташуу, хөндлөн чиглэлээр зурдаг.	Махир зураасны хэлбэрээр дүрсэлж болох амьтныг нэрлэдэг.	Махир зураасаар ургамал, амьтан зурдаг.
ДУТ2.1 ҮД1 Ш4. Үндсэн 5 дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөх аргаар эд юмсыг зурж дүрсэлдэг.	Үндсэн 5 дүрсийг зурж дүрсэлдэг.	Үндсэн 5 дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөн дүрсэлдэг.	Үндсэн 5 дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөх аргаар эд юмсыг зурж буддаг.

2.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ2.1 ҮД2. Сурагч зураг зурахдаа уншсан зүйлийнхээ гол ба туслах дүрийн ялгааг тодорхойлж, наана цаана хол ойр байршлыг давхцуулан зурах аргаар дүрсэлж чаддаг болно.	ДУТ2.1 ҮД2 Ш5. Уншсан сэдвийн агуулгаар зураг зурахдаа гол ба туслах дүрийн ялгааг дүрсэлж тайлбарладаг.
		ДУТ2.1 ҮД2 Ш6. Давхцуулан зурах аргаар юмсын наана, цаана хол, ойр байршлыг дүрсэлдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	I	II	III
ДУТ2.1 ҮД2 Ш5. Уншсан сэдвийн агуулгаар зураг зурахдаа гол ба туслах дүрийн ялгааг дүрсэлж тайлбарладаг.	Уншсан сэдвийн агуулгын утга санааг тайлбарладаг.	Уншсан сэдвийн агуулгаар зураг зурахдаа гол ба туслах дүрийн байршлыг тодорхойлдог.	Уншсан сэдвийн агуулгаар зурсан зургаа усан будаг, гуашаар будаж, хүрээлэх, гол ба туслах дүрийн ялгааг тайлбарладаг.
ДУТ2.1 ҮД2 Ш6. Давхцуулан зурах аргаар юмсын наана, цаана хол, ойр байршлыг дүрсэлдэг.	Юмсын наана цаана, хол ойр байршлыг жишээгээр тайлбарладаг.	Юмсыг наана, цаана хол, ойр байршлыг тодорхойлж дүрсэлдэг.	Давхцуулан зурах аргаар юмсын наана, цаана хол, ойр байршлыг тодорхойлж дүрсэлдэг.

2.2.3. Үнэлгээний нэгж 3. Соёлын үнэт зүйл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ2.1 ҮД3. Сурагч уламжлалт зураг дүрслэлийн талаарх ойлголтоо чулуун дээр зурах болон 2 өнгийг дагнааслах аргаар дүрсэлж харуулдаг болно.	ДУТ2.1 ҮД3 Ш7. Уламжлалт зураг дүрслэлийн (хоёр өнгөөр дагнааслан будах) аргаар цэцэг, навчин хээг зурж дүрсэлдэг.
		ДУТ2.1 ҮД3 Ш8. Хадны зураг дүрслэлийг чулуун дээр тосон харандаагаар зураас ашиглан зурдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	I	II	III
ДУТ2.1 ҮД3 Ш7. Уламжлалт зураг дүрслэлийн (хоёр өнгөөр дагнааслан будах) аргаар цэцэг, навчин хээг зурж дүрсэлдэг.	Хоёр зурвас үүсгэн хэвтээ, босоо чиглэлээр зурдаг.	Зурсан зурвасыг хүнд хөнгөн өнгөөр дагнааслан буддаг.	Хоёр өнгөөр дагнааслан будах аргаар цэцэг, навчин хээг зурж дүрсэлдэг.
ДУТ2.1 ҮД3 Ш8. Хадны зураг дүрслэлийг чулуун дээр тосон харандаагаар зураас ашиглан зурдаг.	Хадны зурагт юу юуг дүрсэлсэн болохыг тоочин нэрлэдэг.	Хадны зураг, дүрслэлд ямар төрлийн зураас ашигласныг тайлбарладаг.	Хадны зургаас сонгож, тосон харандаагаар чулуун дээр шулуун, долгион, нуман, тахир, махир зураас ашиглан зураг зурдаг.

2.2.4. Үнэлгээний нэгж 4. Хоёр ба гурван хэмжээст бүтээл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ2.2 ҮД4. Сурагч үндсэн дүрсээр нийлмэл дүрс үүсгэх болон байгалийн материал (өвс ургамал, навчаар) -ыг өрж эвлүүлэх аргаар 2 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.	ДУТ2.2 ҮД4 Ш9. Үндсэн дүрсээр нийлмэл дүрс үүсгэх аргаар 2 хэмжээст бүтээл хийдэг.
		ДУТ2.2 ҮД4 Ш10. Үндсэн болон нийлмэл дүрсийг эвлүүлэх аргаар 2 хэмжээст техникийн загвар бүтээдэг.
		ДУТ2.2 ҮД4 Ш11. Байгалийн материал (өвс ургамал, навчаар)-ыг өрж эвлүүлэх аргаар 2 хэмжээст бүтээл хийдэг.
2	ДУТ2.2 ҮД5. Сурагч цаасыг зааврын дагуу нугалах болон хуйлах, тэнийлгэх аргаар 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.	ДУТ2.2 ҮД5 Ш12. Цаасыг зааврын дагуу 3-4 нугалж 3 хэмжээст бүтээл хийдэг.
		ДУТ2.2 ҮД5 Ш13. Цаасыг хуйлах, тэнийлгэх аргаар 3 хэмжээст бүтээл хийдэг.

3	ДУТ2.2 ҮД6. Сурагч баримлын шавар болон бусад материалыг хослуулан 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.	ДУТ2.2 ҮД6 Ш14. Баримлын шавар, савх модыг холбох аргаар мал, амьтны загвар хийдэг.
		ДУТ2.2 ҮД6 Ш15. Өнгө өнгийн чулууг баримлын шавраар холбох аргаар амьтны баримал хийдэг.
4	ДУТ2.2 ҮД7. Сурагч төрөл бүрийн материалыг ашиглан хэрэгцээт зүйлс хийдэг болно.	ДУТ2.2 ҮД7 Ш16.Төрөл бүрийн материал ашиглан хэрэгцээтэй зүйлс (номын хавчуурга) хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин		
	I	II	III
ДУТ2.2 ҮД4 Ш9. Үндсэн дүрсээр нийлмэл дүрс үүсгэх аргаар 2 хэмжээст бүтээл хийдэг.	Үндсэн дүрсээр нийлмэл дүрс бүтээдэг.	Үндсэн болон нийлмэл дүрсийг өрж эвлүүлэн шинэ хэлбэр бүтээдэг.	Үндсэн болон нийлмэл дүрсийг өрж эвлүүлэн шинэ хэлбэр, дүрс үүсгэх аргаар зохиомжлон 2 хэмжээст бүтээл хийдэг.
ДУТ2.2 ҮД4 Ш10. Үндсэн болон нийлмэл дүрсийг эвлүүлэх аргаар 2 хэмжээст техникийн загвар бүтээдэг.	Техникийн загварт тохирох үндсэн ба нийлмэл дүрсийг зурж хайчилдаг.	Үндсэн болон нийлмэл дүрсийг эвлүүлж 2 хэмжээст техникийн загвар бүтээдэг.	Үндсэн болон нийлмэл дүрсийн байрлалыг өөрчлөх аргаар техникийн шинэ загвар бүтээдэг.
ДУТ2.2 ҮД4 Ш11. Байгалийн материал (өвс ургамал, навчаар)-ыг өрж эвлүүлэх аргаар 2 хэмжээст бүтээл хийдэг.	Бүтээлийг ажиглан байгалийн ямар материалаар юуг яаж хийсэн болохыг тайлбарладаг.	Байгалийн материал (өвс ургамал, навч)-ыг сонгон өрж 2 хэмжээст дүрс үүсгэдэг.	Байгалийн материал (өвс ургамал, навчаар)-ыг өрж эвлүүлэн наах аргаар 2 хэмжээст бүтээл хийдэг.
ДУТ2.2 ҮД5 Ш12. Цаасыг зааврын дагуу 3-4 нугалж 3 хэмжээст бүтээл хийдэг.	Цаасыг 3-4 нугалж бүтээх зурган зааврыг тайлбарладаг.	Зааврын дагуу цаасыг 2-3 нугалах алхмыг гүйцэтгэдэг.	Цаасыг зааврын дагуу 3-4 нугалж 3 хэмжээст бүтээл хийдэг.
ДУТ2.2 ҮД5 Ш13. Цаасыг хуйлах, тэнийлгэх аргаар 3 хэмжээст бүтээл хийдэг.	Цаасыг (харандаагаар гол хийж) шулуун болон ташуу чиглэлд хуйлдаг.	Цаасыг хуйлах, тэнийлгэх аргаар 3 хэмжээст бүтээлийн бүрдэл хэсгийг хийдэг.	Цаасыг хуйлах, тэнийлгэх аргаар хийсэн бүрдэл хэсгийг холбож 3 хэмжээст бүтээл хийдэг.
ДУТ2.2 ҮД6 Ш14. Баримлын шавар, савх модыг холбох аргаар мал, амьтны загвар хийдэг.	Мал, амьтан, юмсын бүрдэл хэсгийг нэрлэдэг.	Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх, цувих, хэрчих, бөөрөнхийлөх аргаар мал, амьтан, юмсын бүрдэл хэсгийг хийдэг.	Баримлын шавраар хийсэн бүрдэл хэсгийг савх модоор холбох аргаар мал, амьтны загварыг хийдэг.
ДУТ2.2 ҮД6 Ш15. Өнгө өнгийн чулууг баримлын шавраар холбох аргаар амьтны баримал хийдэг.	Амьтны баримал хийх өнгө өнгийн чулууг гадаад байдлаар таньж сонгодог.	Өнгө өнгийн чулууг өрж амьтны дүрс бүтээдэг.	Өнгө өнгийн чулууг баримлын шавраар холбох аргаар амьтны баримал бүтээдэг.
ДУТ2.2 ҮД7 Ш16.Төрөл бүрийн материал ашиглан хэрэгцээтэй зүйлс (номын хавчуурга) хийдэг.	Номын хавчуурга хийх тохирох материалыг сонгодог.	Номын хавчуургын бүрдэл хэсгийг хийж бэлтгэдэг.	Сонгосон материал (төрөл бүрийн материал)-аар номын хавчуургыг хийж чимэглэдэг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. III АНГИ

3.1. III АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	3.1а. Өнгийн хүрдийг ажиглаж дулаан, хүйтэн өнгийг ялгааг таньж тодорхойлох 3.1б. Дулаан, хүйтэн өнгийг байгалийн зураг дүрслэлд ашиглах 3.1в. Санамсаргүйгээр толбо үүсгэх аргыг зураг дүрслэлдээ ашиглах 3.1г. Юмсын хатуу, зөөлөн, тогтвортой, хөдөлгөөнтэй зэрэг шинж чанарыг зураасны төрлүүдээр илэрхийлэх 3.1д. Үндсэн дүрсүүдийг дардаслан олшруулах аргаар зохиомжийн ойлголтоо харуулах	Дүрслэлийн хэл	ДУТ3.1 ҮД1. Сурагч зохиомжийн хэрэгслүүд (дулаан, хүйтэн өнгө, толбо үүсгэх арга, зураасны шинж чанар, дүрсийн давтамж)- ийг таньж тодорхойлох, тэдгээрийг ашиглан зурж дүрсэлдэг болно.
2	3.1е. Хүүхдийн зураг, бүтээлүүдээс төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлэх 3.1ж. Бодит болон хийсвэр зургийг харьцуулан орон зай илэрхийллийн ялгааг тайлбарлах	Урлан бүтээхүй	ДУТ3.1 ҮД2. Сурагч уран зургийн бүтээлүүдээс гол ба туслах дүр болон орон зайн илэрхийллийг харьцуулан тодорхойлж ойлголтоо зураг дүрслэлээр илэрхийлнэ.
3	3.1з. Монголын зураачдын уран зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах 3.1и. Гурван өнгөөр дагнааслан будах аргаар эвэр угалз дүрслэх	Соёлын үнэт зүйл	ДУТ3.1 ҮД3. Сурагч монголын уламжлалт зураг дүрслэлийн ойлголтоо уран зургийн бүтээлийн жишээгээр тайлбарлах, 3 өнгийг дагнааслах аргаар дүрсэлдэг болно.
4	3.2а. Үндсэн ба нийлмэл дүрсийн хэлбэрийг өөрчлөх аргаар загвар бүтээх 3.2з. Байгалийн материалыг зохиомжлон наах, холбох аргаар бүтээл хийх 3.2б. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж загвар бүтээх 3.2в. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээх 3.2г. Хатуу цаасыг хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны загвар бүтээх 3.2д. Цаасыг нугалж хайчлах аргаар тэгш хэмийн ойлголтыг тайлбарлах 3.2е. Цаасыг тэгш хэмээр нугалж, хайчлах аргаар техникийн загвар бүтээх 3.2ж. Эд ангийг үлгэр ашиглан зурж хайчилж угсрах аргаар техникийн загвар бүтээх 3.2к. Баримлын шавраар хийсэн геометрийн энгийн биетүүдийг өрж холбох аргаар хэлбэрийг өөрчлөх, хувиргах 3.2л. Баримлаар хийсэн амьтад, юмсын загварыг зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээх 3.2и. Янз бүрийн материалыг будаж хооронд нь холбох, хайчлах, чимэглэх аргаар бүтээл хийх 3.2м. Өнгийн ноосон утас ашиглан бөмбөлөг хийх аргаар бүтээл хийх 3.2н. Зүүлтийн гоёл чимэглэлд өнгийн ноосон утсыг хатуу цаасанд ороох, цаасны ирмэг дагуу хайчлах, цацагласан утсаа багцалж боох аргыг ашиглах	Хоёр ба гурван хэмжээст бүтээл	ДУТ3.2 ҮД4. Сурагч дүрс (үндсэн ба нийлмэл) болон байгалийн материал (өвс ургамал, навч, үр тариа)-ыг зохиомжлон нааж холбох аргаар 2 ба 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно. ДУТ3.2 ҮД5. Сурагч цаасыг нугалах, хуйлж хэлбэршүүлэх болон үлгэр ашиглах зурж, хайчин угсрах аргаар 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно. ДУТ3.2 ҮД6. Сурагч баримлын шавраар юмсын загвар хийж зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээж чаддаг болно. ДУТ3.2 ҮД7. Сурагч төрөл бүрийн материалыг холбох, хайчлах, чимэглэх аргаар бүтээл хийж чаддаг болно.

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР,
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

3.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТЗ.1 ҮД1. Сурагч зохиомжийн хэрэгслүүд (дулаан, хүйтэн өнгө, толбо үүсгэх арга, зураасны шинж чанар, дүрсийн давтамж)-ийг таньж тодорхойлох, тэдгээрийг ашиглан зурж дүрсэлдэг болно.	ДУТЗ.1 ҮД1 Ш1. Дулаан, хүйтэн өнгийг ялган таньж тодорхойлох замаар дулаан, хүйтэн өнгөөр илэрхийлсэн зураг зурдаг.
		ДУТЗ.1 ҮД1 Ш2. Санамсаргүйгээр үүсгэсэн толбоор дүрс бүтээх аргаар зураг зурдаг.
		ДУТЗ.1 ҮД1 Ш3. Юмсын тогтвортой, хөдөлгөөнтэй шинж чанарыг зураасны төрлүүдээр илэрхийлэн дүрсэлдэг.
		ДУТЗ.1 ҮД1 Ш4. Үндсэн дүрсүүдийг дардаслан олшруулах аргаар зурж дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТЗ.1 ҮД1 Ш1. Дулаан, хүйтэн өнгийг ялган таньж тодорхойлох замаар дулаан, хүйтэн өнгөөр илэрхийлсэн зураг зурдаг.	Дулаан, хүйтэн өнгийг ялган таньж нэрлэдэг.	Өнгийг хүрдээс дулаан, хүйтэн өнгийг ялган нэрлэж тайлбарладаг.	Дулаан, хүйтэн өнгийн онцлогийг бүтээлийн жишээгээр тайлбарладаг.	Байгалийн зураг дүрслэлийг дулаан, хүйтэн өнгөөр илэрхийлж зурдаг.
ДУТЗ.1 ҮД1 Ш2. Санамсаргүйгээр үүсгэсэн толбоор дүрс бүтээх аргаар зураг зурдаг.	Санамсаргүй толбо үүсгэх аргыг тайлбарладаг.	Янз бүрийн хэлбэр, хэмжээ бүхий санамсаргүй толбо үүсгэдэг.	Янз бүрийн хэлбэр, хэмжээ бүхий санамсаргүй үүсгэсэн толбоор дүрс бүтээж зурдаг.	Санамсаргүй үүсгэсэн толбоор дүрс бүтээж баяжуулан зураг зурдаг.
ДУТЗ.1 ҮД1 Ш3. Юмсын тогтвортой, хөдөлгөөнтэй шинж чанарыг зураасны төрлүүдээр илэрхийлэн дүрсэлдэг.	Зураасны хэлбэрийг ажиглаж, ямар төрлийн зураас болохыг нэрлэдэг.	Зураасны төрлүүдийг дүрсэлж, аль нь хөдөлгөөнтэй, тогтвортой шинж чанартай болохыг тайлбарладаг.	Хатуу картон цаасыг хэлбэрт оруулан ирмэгт нь усан будаг түрхэн дардаслах аргаар хөдөлгөөнтэй, тогтвортой шинж чанарын зураасаар илэрхийлдэг.	Юмсын тогтвортой, хөдөлгөөнтэй шинж чанарыг зураасны төрлөөр илэрхийлсэн зураг зурдаг.
ДУТЗ.1 ҮД1 Ш4. Үндсэн дүрсүүдийг дардаслан олшруулах аргаар зурж дүрсэлдэг.	Картон цаасаар хийсэн үндсэн дүрс бүхий дардасыг хэлбэрээр нь ялган нэрлэдэг.	Дардаслан олшруулах аргаар үндсэн дүрсийг үүсгэн зурдаг.	Давтамж үүсгэн дардаслах аргаар төрөл бүрийн хэлбэр үүсгэж зурдаг.	Дардаслан олшруулах аргаар үндсэн дүрсийн чөлөөт зохиомж зурдаг.

3.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ3.1 ҮД2. Сурагч уран зургийн бүтээлүүдээс гол ба туслах дүр болон орон зайн илэрхийллийг харьцуулан тодорхойлж ойлголтоо зураг дүрслэлээр илэрхийлнэ.	ДУТ3.1 ҮД2 Ш5. Хүүхдийн зураг бүтээлээс гол ба туслах дүрийн онцлогийг тодорхойлж төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлдэг.
		ДУТ3.1 ҮД2 Ш6. Бодит ба хийсвэр зургийг харьцуулан орон зай илэрхийллийн ялгааг тодорхойлж төрсөн сэтгэгдлээ дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ3.1 ҮД2 Ш5. Хүүхдийн зураг бүтээлээс гол ба туслах дүрийн онцлогийг тодорхойлж төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлдэг.	Хүүхдийн зураг, бүтээлийн дүр, дүрслэлийг тоочин нэрлэдэг.	Хүүхдийн зураг, бүтээлийн гол ба туслах дүрийг ялгаж нэрлэдэг.	Хүүхдийн зураг, бүтээлийн гол ба туслах дүрийн онцлогийг тодорхойлдог.	Хүүхдийн зураг, бүтээлээс төрсөн сэтгэгдлээ зургаар илэрхийлдэг.
ДУТ3.1 ҮД2 Ш6. Бодит ба хийсвэр зургийг харьцуулан орон зай илэрхийллийн ялгааг тодорхойлж төрсөн сэтгэгдлээ дүрсэлдэг.	Хүүхдийн зургийн аль нь бодит ба хийсвэр /төсөөллийн/ зураг болохыг ялгадаг.	Бодит ба хийсвэр /төсөөллийн/ зургийг харьцуулан ялгааг тайлбарладаг.	Бодит ба хийсвэр /төсөөллийн/ зургийг харьцуулан орон зай ялгааг тодорхойлж тайлбарладаг.	Бодит ба хийсвэр /төсөөллийн/ зургаас төрсөн сэтгэгдлээ дүрсэлдэг.

3.2.3. Үнэлгээний нэгж 3. Соёлын үнэт зүйл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ3.1 ҮД3. Сурагч монголын уламжлалт зураг дүрслэлийн ойлголтоо уран зургийн бүтээлийн жишээгээр тайлбарлах, 3 өнгийг дагнааслах аргаар дүрсэлдэг болно.	ДУТ3.1 ҮД3 Ш7. Монголын зураачдын уран зургийг бүтээлийн жишээн дээр тайлбарладаг.
		ДУТ3.1 ҮД3 Ш8. Монголын уламжлалт зураг дүрслэлийн ойлголтоо гурван өнгөөр дагнааслах аргаар хээ, угалз дүрсэлж илэрхийлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ3.1 ҮД3 Ш7. Монголын зураачдын уран зургийг бүтээлийн жишээн дээр тайлбарладаг.	Сурах бичгийн агуулгаас сонгосон уран зургийг нэрлэдэг.	Сонгосон уран зургийн дүр, дүрслэлийг зургийн нэртэй холбон тайлбарладаг.	Уран зургийн бүтээлийн үйл явдал, утга санааг тайлбарладаг.	Уран зургийн бүтээлийн онцлогийг баримтад тулгуурлан тайлбарладаг.
ДУТ3.1 ҮД3 Ш8. Монголын уламжлалт зураг дүрслэлийн ойлголтоо гурван өнгөөр дагнааслах аргаар хээ, угалз дүрсэлж илэрхийлдэг.	Эвэр угалзыг зурж дүрсэлдэг.	Эвэр угалзыг гурван зурвас үүсгэн зурж дүрсэлдэг.	Эвэр угалзыг гурван өнгөөр зурвас үүсгэн дагнааслан буддаг.	Гурван өнгөөр зурвас үүсгэн дагнааслах аргаар уул, үүл, ус, хээ зурж чаддаг.

3.2.4. Үнэлгээний нэгж 4. Хоёр ба гурван хэмжээст бүтээл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ3.2 ҮД4. Сурагч дүрс (үндсэн ба нийлмэл) болон байгалийн материал (өвс ургамал, навч, үр тариа)-ыг зохиомжлон нааж холбох аргаар 2 ба 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.	ДУТ3.2 ҮД4 Ш9. Үндсэн ба нийлмэл дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөн нааж холбох аргаар 2 ба 3 хэмжээст загвар бүтээдэг.
		ДУТ3.2 ҮД4 Ш10. Байгалийн материалыг зохиомжлон нааж холбох аргаар 2 ба 3 хэмжээст бүтээл хийдэг.
2	ДУТ3.2 ҮД5. Сурагч цаасыг нугалах, хуйлж хэлбэршүүлэх болон үлгэр ашиглах зурж, хайчилж угсрах аргаар 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно.	ДУТ3.2 ҮД5 Ш11. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж 3 хэмжээст загвар бүтээдэг.
		ДУТ3.2 ҮД5 Ш12. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээдэг.
		ДУТ3.2 ҮД5 Ш13. Хатуу цаасыг хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны 3 хэмжээст загвар бүтээдэг.
		ДУТ3.2 ҮД5 Ш14. Үлгэр ашиглан эд ангийг зурж хайчилж угсрах аргаар техникийн 3 хэмжээст загвар бүтээдэг.
3	ДУТ3.2 ҮД6. Сурагч баримлын шавраар юмсын загвар хийж зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээж чаддаг болно.	ДУТ3.2 ҮД6 Ш15. Баримлын шавраар юмсын загвар хийж зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээдэг.
4	ДУТ3.2 ҮД7. Сурагч төрөл бүрийн материалыг холбох, хайчлах, чимэглэх аргаар бүтээл хийж чаддаг болно.	ДУТ3.2 ҮД7 Ш16. Төрөл бүрийн материалыг хайчлах, холбох, будаж чимэглэх аргаар бүтээл хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ3.2 ҮД4 Ш9. Үндсэн ба нийлмэл дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөн нааж холбох аргаар 2 ба 3 хэмжээст загвар бүтээдэг.	Үндсэн ба нийлмэл дүрсийг таллан хайчлах аргаар хэлбэр, хэмжээг өөрчилдөг.	Хэлбэр, хэмжээг өөрчилсөн үндсэн ба нийлмэл дүрсээр янз бүрийн дүрсэн загвар үүсгэдэг.	Үндсэн ба нийлмэл дүрсийн хэлбэр, хэмжээг өөрчлөн наах аргаар 2 хэмжээст загвар бүтээдэг.	Үндсэн ба нийлмэл дүрсийг нааж холбох аргаар (3 хэмжээст) биет загвар бүтээдэг.
ДУТ3.2 ҮД4 Ш10. Байгалийн материалыг зохиомжлон нааж холбох аргаар 2 ба 3 хэмжээст бүтээл хийдэг.	Байгалийн материалыг гадаад байдлаар нь ялгах таньж бүтээлдээ сонгодог.	Байгалийн материалын хэлбэрийг ажиглан өрж янз бүрийн дүрс үүсгэдэг.	Байгалийн материалыг зохиомжлон наах, аргаар 2 хэмжээст бүтээл хийдэг.	Байгалийн материалыг зохиомжлон наах, холбох аргаар 3 хэмжээст бүтээл хийдэг.

ДУТ3.2 ҮД5 Ш11. Зааврын дагуу цаасыг 5-аас дээш нугалж 3 хэмжээст загвар бүтээдэг.	5-аас дээш нугалж бүтээх зурган зааврыг уншиж тайлбарладаг.	1-2 нугалааг зааврын дагуу гүйцэтгэдэг.	3-4 нугалааг зааврын дагуу гүйцэтгэдэг.	5-аас дээш нугалааг зааврын дагуу гүйцэтгэж 3 хэмжээст загвар бүтээдэг.
ДУТ3.2 ҮД5 Ш12. Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар бүтээдэг.	Цаасыг 1 нугалж хайчлан тэгш хэмт дүрс үүсгэж тайлбарладаг.	Бүтээлийн онцлогт нийцүүлэн цаасыг сонгож давхарлан нугалж бэлтгэдэг.	Нугалж бэлтгэсэн цаасан дээр олон дүрс үүсгэх аргаар тохирох дүрсийг зурдаг.	Цаасыг нугалж хайчлан олон дүрс үүсгэх аргаар тэгш хэмт чимэглэлийн загвар хийдэг.
ДУТ3.2 ҮД5 Ш13. Хатуу цаасыг хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны 3 хэмжээст загвар бүтээдэг.	Завсартаа зөөлөвчтэй хайрцгийн зөөлөн картоныг хуулж, зөөлөвчийг туузлан хайчилдаг.	Зөөлөвчтэй туузан картоныг хуйлж хэлбэржүүлэн янз бүрийн амьтны хэлбэр үүсгэж туршдаг.	Цаасаа хуйлж хэлбэржүүлэх аргаар амьтны бүрдэл хэсгүүдийг бэлтгэдэг.	Бүрдэл хэсгүүдийг нааж холбох аргаар 3 хэмжээст загвар бүтээдэг.
ДУТ3.2 ҮД5 Ш14. Үлгэр ашиглан эд ангийг зурж хайчилж угсрах аргаар техникийн 3 хэмжээст загвар бүтээдэг.	Үлгэр зургаас техникийн загварын эд анги бүрдэл хэсгийг нэрлэдэг.	Техникийн загварын онцлогт нийцүүлэн материалыг сонгодог.	Үлгэрийн дагуу техникийн загварын эд анги бүрдэл хэсгийг зурж, хайчилж бэлтгэдэг.	Үлгэрийн дагуу эд анги бүрдэл хэсгийг зурж, хайчилж угсран техникийн 3 хэмжээст загвар бүтээдэг.
ДУТ3.2 ҮД6 Ш15. Баримлын шавраар юмсын загвар хийж зохиомжлон байрлуулах аргаар үйл явдал илэрхийлсэн баримал бүтээдэг.	Баримлаар үйл явдал илэрхийлсэн бүтээл хийх сэдвээ сонгон тайлбарладаг.	Сэдвийн дагуу юмсын загварын бүрдэл хэсгийг баримлаар бүтээдэг.	Баримлаар хийсэн бүрдэл хэсгийг холбох аргаар загварыг бүтээдэг.	Юмсын загварыг зохиомжлон байрлуулж үйл явдал илэрхийлсэн баримал бүтээдэг.
ДУТ3.2 ҮД7 Ш16. Төрөл бүрийн материалыг хайчлах, холбох, будаж чимэглэх аргаар бүтээл хийдэг.	Төрөл бүрийн материалаар бүтээл хийх арга аргачлалыг бүтээлийн жишээгээр тайлбарладаг.	Бүтээлийн онцлогт нийцүүлэн материалыг сонгодог.	Бүтээлийн онцлогт нийцүүлэн материалыг хэлбэрийг өөрчилж бүрдэл хэсгүүдийг бүтээдэг.	Төрөл бүрийн материалыг холбож будаж чимэглэх аргаар бүтээл хийдэг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IV АНГИ

4.1. IV АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	4.1а. Өнгийн хүрднээс эсрэг өнгийг байрлалаар нь ялгаж, эсрэг өнгийн ялгарлыг ажиглан тодорхойлох 4.1б. Эсрэг өнгийн ялгарлыг зураг дүрслэлдээ ашиглах 4.1в. Төрөл бүрийн материалаар толболох аргыг зураг дүрслэлдээ ашиглах 4.1г. Хөгжмийн аялгууг сонсоод зураасны төрлүүдээр илэрхийлэх	Дүрслэлийн хэл	ДУТ4.1 ҮД1. Сурагч зохиомжийн хэрэгслүүд (эсрэг өнгө, толбо, зураасны илэрхийлэл, давтамж)- ийг таньж тодорхойлох тэдгээрийг ажиглан зурж дүрсэлж чаддаг болно.
2	4.1д. Нэг төвт зохиомжийн онцлогийг зураачдын бүтээлийн жишээн дээр тайлбарлах 4.1е. Үндсэн дүрс ба биетийг бүтээхдээ орон зайн ялгааг анзаарах 4.1ж. Амьтны биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан дүрслэх 4.1з. Араг зургийн аргаар амьтдын хөдөлгөөнийг дүрслэх	Урлан бүтээхүй	ДУТ4.1 ҮД2. Сурагч нэг төвт зохиомжийн онцлог, дүрс биетийн орон зайн ялгааг зураг дүрслэлээр илэрхийлэх, амьтан зурах аргачлалаар зурж чаддаг болно.
3	4.1и. Хүүхдийн болон монгол зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах 4.1к. Мартан, нагтан зургийн аргаар өөрийн бодол төсөөллийг дүрслэх	Соёлын үнэт зүйл	ДУТ4.1 ҮД3. Сурагч монголын уламжлалт уран зургийн бүтээлийг тайлбарлах, өөрийн бодол төсөөллийг мартан, нагтан зургийн аргаар дүрсэлж чаддаг болно.
4	4.2а. Цаасны үүсэл болон боловсруулах үе шатыг жишээн дээр тайлбарлах 4.2з. Цаасыг хэлбэрт оруулж тугалган цаасаар бүрэх аргаар амьтдын баримал урлах 4.2б. Цаасан хайрцаг задалж тэгш өнцөгт биетийн дэлгээс судалж тайлбарлах 4.2в. Тэгш өнцөгт биетийн дэлгээс байгуулах аргаар тоглоомын загвар бүтээх 4.2г. Хавтгай дүрсүүдийг сэтэлж хайчлах аргаар холбож 3 хэмжээст бүтээл хийх 4.2е. Туузан цаасыг хэлбэр үүсгэн холбох аргаар 3 хэмжээст чимэглэлийн бүтээл хийх 4.2ж. Шигтгэж чимэглэл хийхэд байгалийн материал (будаа, чулуу, самрын яс)-ыг ашиглах 4.2д. Төрөл бүрийн биетүүдийг загварчлах аргаар бүтээл хийх 4.2и. Хаягдал материалаар хүндрүүлэгч ачаа, харимхай металл салхины хүч ашиглан техникийн загвар бүтээх	Хоёр ба гурван хэмжээст бүтээл	ДУТ4.2 ҮД4. Сурагч цаасны үүсэл боловсруулах үе шатыг судлах замаар хэрэглээнээс гарсан цаасаар 3 хэмжээст баримал бүтээж чаддаг болно. ДУТ4.2 ҮД5. Сурагч тэгш өнцөгт биет (куб, параллелепипед)-ийн дэлгээсийг судалж бүтээх болон цаасыг хэлбэр үүсгэн холбох, сэтэлж хайчилж угсрах аргаар 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно. ДУТ4.2 ҮД6. Сурагч төрөл бүрийн материал, биетийг холбож загварчлах болон байгалийн материал (будаа, чулуу, самрын яс гэх мэт)-ыг шигтгэх аргаар бүтээл хийж чаддаг болно.
	4.2к. Гар оёдлын багаж хэрэгслийг жижиг эдлэл хийхэд ашиглах 4.2л. 2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зууш бэлтгэх 4.2м. Ажил мэргэжлийн онцлогийг жишээгээр тайлбарлах	Ажил мэргэжил, амьдрах ухаан	ДУТ4.2 ҮД7. Сурагч ажил мэргэжлийн онцлог болон өөртөө үйлчлэх арга барилын талаарх ойлголтоо гар оёдлоор оёх, хөнгөн зууш бэлтгэж харуулна.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

4.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

4.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ4.1 ҮД1 Сурагч зохиомжийн хэрэгслүүд (эсрэг өнгө, толбо, зураасны илэрхийлэл, давтамж гэх мэт)- ийг таньж тодорхойлох, тэдгээрийг ашиглан зурж дүрсэлдэг болно.	ДУТ4.1 ҮД1 Ш1. Эсрэг өнгийг таньж ялгарлыг тодорхойлох замаар эсрэг өнгийг сонгож зураг зурдаг.
		ДУТ4.1 ҮД1 Ш2. Төрөл бүрийн материалаар толболох аргаар зурж дүрсэлдэг.
		ДУТ4.1 ҮД1 Ш3. Хөгжмийн аялгууг сонсоод хөгжмийн өнгө аясыг (зөөлөн, тогтвортой, хөдөлгөөнтэй шинж чанарыг) зураасны төрлүүдээр илэрхийлж дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ4.1 ҮД1 Ш1. Эсрэг өнгийг таньж ялгарлыг тодорхойлох замаар эсрэг өнгийг сонгож зураг зурдаг.	Өнгийн хүрдээс эсрэг өнгийг байршлаар нь таньж нэрлэдэг.	Эсрэг өнгүүдийн ялгарал онцлогийг тодорхойлж тайлбарладаг.	Эсрэг өнгийн ялгарлыг гаргаж дүрсэлдэг.	Сэдэв сонгож эсрэг өнгийн ялгарлыг илэрхийлсэн зураг зурдаг.
ДУТ4.1 ҮД1 Ш2. Төрөл бүрийн материалаар толболох аргаар зурж дүрсэлдэг.	Төрөл бүрийн материалаар толбо үүсгэх аргуудыг тайлбарладаг.	Төрөл бүрийн материалаар янз бүрийн хэлбэр, хэмжээ бүхий толбо үүсгэн дүрсэлдэг.	Янз бүрийн хэлбэр, хэмжээ бүхий толбоор дүрс бүтээдэг.	Төрөл бүрийн материалаар толболох аргаар зураг зурдаг.
ДУТ4.1 ҮД1 Ш3. Хөгжмийн аялгууг сонсоод хөгжмийн өнгө аясыг (зөөлөн, тогтвортой, хөдөлгөөнтэй шинж чанарыг) зураасны төрлүүдээр илэрхийлж дүрсэлдэг.	Хөгжмийн аялгууг сонсоод хөгжмийн өнгө аясын ялгааг тайлбарладаг.	Хөгжмийн өнгө аясыг зөөлөн, тогтвортой, хөдөлгөөнтэй шинж чанартай холбон тайлбарладаг.	Хөгжмийн аялгууны өнгө аясыг (зөөлөн, тогтвортой, хөдөлгөөнтэй шинж чанарыг) зураасаар илэрхийлж дүрсэлдэг.	Хөгжмийн аялгууг зураасны төрлүүдээр илэрхийлсэн зураг зурдаг.

4.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ4.1 ҮД2. Сурагч нэг төвт зохиомжийн онцлог, дүрс биетийн орон зайн ялгааг зураг дүрслэлээр илэрхийлэх, амьтан зурах аргачлалаар зурж чаддаг болно.	ДУТ4.1 ҮД2 Ш4. Нэг төвт зохиомжийн онцлогийг бүтээлийн жишээн дээр тодорхойлж тайлбарлах замаар ойлголтоо зургаар илэрхийлдэг.
		ДУТ4.1 ҮД2 Ш5. Үндсэн дүрс ба биетийг харьцуулж орон зай ялгааг тайлбарлах замаар ойлголтоо дүрсэлж илэрхийлдэг.
		ДУТ4.1 ҮД2 Ш6. Биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан араг (бүдүүвч) зургийн аргаар амьтны хөдөлгөөнийг дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ4.1 ҮД2 Ш4. Нэг төвт зохиомжийн онцлогийг бүтээлийн жишээн дээр тодорхойлж тайлбарлах замаар ойлголтоо зургаар илэрхийлдэг.	Нэг төвт зохиомжийн онцлогийг харуулсан бүтээлийн дүр дүрслэлийг тоочин нэрлэдэг.	Нэг төвт зохиомжийн онцлогийг харуулсан бүтээлээс гол ба туслах дүрийг тодорхойлдог.	Бүтээлийн жишээн дээр нэг төвт зохиомжийн онцлогийг тодорхойлж тайлбарладаг.	Нэг төвт зохиомжийн онцлогийг харуулсан зураг зурдаг.
ДУТ4.1 ҮД2 Ш5. Үндсэн дүрс ба биетийг харьцуулж орон зай ялгааг тайлбарлах замаар ойлголтоо дүрсэлж илэрхийлдэг.	Үндсэн дүрс ба биетийг ялгаж нэрлэдэг.	Үндсэн дүрс ба биетийг харьцуулан ялгааг тайлбарладаг.	Үндсэн дүрс ба биетийг харьцуулж ялгааг орон зайн дүрслэлтэй холбон тайлбарладаг.	Үндсэн дүрс ба биетийн орон зай ялгааг илэрхийлсэн зураг зурдаг.
ДУТ4.1 ҮД2 Ш6. Биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан араг (бүдүүвч) зургийн аргаар амьтны хөдөлгөөнийг дүрсэлдэг.	Сонгосон мал, амьтнаа бүдүүвчээр дүрсэлдэг.	Мал, амьтны хөдөлгөөний өөрчлөлтийг бүдүүвчээр дүрсэлдэг.	Бүдүүвчээр дүрсэлсэн мал амьтны дүрслэлийг биежүүлэн зурдаг.	Биежүүлэн зурсан мал, амьтны зургаа тодруулан зурж буддаг.

4.2.3. Үнэлгээний нэгж 3. Соёлын үнэт зүйл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ4.1 ҮД3. Сурагч монголын уламжлалт уран зургийн бүтээлийг тайлбарлах, өөрийн бодол төсөөллийг мартан, нагтан зургийн аргаар дүрсэлнэ.	ДУТ4.1 ҮД3 Ш7. Монголын зураачдын болон хүүхдийн бүтээлийг жишээн дээр тайлбарладаг, бүтээлээс санаа авч монгол зургийн аргаар зураг зурдаг.
		ДУТ4.1 ҮД3 Ш8. Мартан, нагтан зургийн ялгаа, онцлогийг тодорхойлох замаар мартан, нагтан зураг зурдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ4.1 ҮД3 Ш7. Монголын зураачдын болон хүүхдийн бүтээлийг жишээн дээр тайлбарладаг, бүтээлээс санаа авч монгол зургийн аргаар зураг зурдаг.	Монгол зургийн аргаар зурсан зураачийн уран зураг, хүүхдийн бүтээлийн дүр, дүрслэлийг тоочин нэрлэдэг.	Монгол зургийн үйл явдал, дүр, дүрслэл онцлогийг зураачдын болон хүүхдийн бүтээлийн жишээн дээр тайлбарладаг.	Монгол зургийн дүр, дүрслэл онцлог, зурах аргачлалыг дүрсэлж тайлбарладаг.	Зураачдын ба хүүхдийн бүтээлээс санаа авч монгол зургийн аргаар зураг зурдаг.
ДУТ4.1 ҮД3 Ш8. Мартан, нагтан зургийн ялгаа, онцлогийг тодорхойлох замаар мартан, нагтан зураг зурдаг.	Мартан, нагтан зургийг таньж нэрлэдэг.	Мартан, нагтан зургийн ялгаа, онцлогийг тодорхойлж тайлбарладаг.	Мартан, нагтан зураг зурах аргыг жишээгээр тайлбарладаг.	Мартан, нагтан зураг зурж дүрсэлдэг.

4.2.4. Үнэлгээний нэгж 4. Хоёр ба гурван хэмжээст бүтээл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ4.2 ҮД4. Сурагч цаасны үүсэл боловсруулах үе шатыг судлах замаар хэрэглээнээс гарсан цаасаар 3 хэмжээст баримал бүтээж чаддаг болно.	ДУТ4.2 ҮД4 Ш9. Цаасны үүсэл, боловсруулах үе шат, цаас (нимгэн, картон)-ны шинж чанар, хэрэглээг жишээн дээр тайлбарладаг.
		ДУТ4.2 ҮД4 Ш10. Хэрэглээнээс гарсан цаасыг сонгож, хэлбэрт оруулж тугалган цаасаар бүрэх аргаар амьтдын баримал бүтээдэг.
2	ДУТ4.2 ҮД5. Сурагч тэгш өнцөгт биет (куб, параллелепипед)-ийн дэлгээсийг судалж бүтээх болон цаасыг хэлбэр үүсгэн холбох, сэтэлж хайчилж угсрах аргаар 3 хэмжээст бүтээл хийдэг болно.	ДУТ4.2 ҮД5 Ш11. Тэгш өнцөгт биетийн дэлгээсийг судалж, бүтээх аргаар тоглоомын загвар хийдэг.
		ДУТ4.2 ҮД5 Ш12. Хавтгай дүрсүүдийг сэтэлж хайчлах аргаар холбож 3 хэмжээст бүтээл хийдэг.
		ДУТ4.2 ҮД5 Ш13. Туузан цаасыг хэлбэр үүсгэн холбох аргаар 3 хэмжээст чимэглэлийн бүтээл хийдэг.
3	ДУТ4.2 ҮД6. Сурагч төрөл бүрийн материал, биетийг холбож загварчлах болон байгалийн материал (будaa, чулуу, самрын яс гэх мэт)-ыг шигтгэх аргаар бүтээл хийж чаддаг болно.	ДУТ4.2 ҮД6 Ш14. Төрөл бүрийн биет (хэрэглээнээс гарсан шил)-ийг байгалийн материал (будaa, чулуу, самрын яс)-ыг баримлын шаварт шигтгэх аргаар чимэглэдэг.
		ДУТ4.2 ҮД6 Ш15. Төрөл бүрийн биетийг холбох хүндрүүлэгч ачаа, харимхай металл салхины хүч ашиглан хөдөлгөөнт техникийн загвар бүтээдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ4.2 ҮД4 Ш9. Цаасны үүсэл, боловсруулах үе шат, цаас (нимгэн, картон)-ны шинж чанар, хэрэглээг жишээн дээр тайлбарладаг.	Цаасыг юугаар бүтээгддэг болохыг нэрлэдэг.	Цаасны үүслийн тухай жишээгээр тайлбарладаг.	Цаас боловсруулах үе шатыг жишээн дээр тайлбарладаг.	Нимгэн ба картон цаасны шинж чанарыг хэрэглээний жишээн дээр харьцуулж тайлбарладаг.
ДУТ4.2 ҮД4 Ш10. Цаасыг оновчтой сонгож, хэлбэрт оруулж тугалган цаасаар бүрэх аргаар амьтдын баримал бүтээдэг.	Бүтээлийн онцлогт нийцүүлэн (хэрэглээнээс гарсан, нимгэн) цаасыг сонгож чаддаг.	Хэрэглээнээс гарсан цаасыг базаж амьтны ерөнхий хэлбэрийг бүтээдэг.	Хэлбэр үүсгэсэн цаасаа тугалган цаасаар бүрж амьтны баримал бүтээдэг.	Цаасыг хэлбэрт оруулж тугалган цаасаар бүрэх аргаар өөр өөр амьтны баримлыг бүтээдэг.
ДУТ4.2 ҮД5 Ш11. Тэгш өнцөгт биетийн дэлгээсийг судалж, бүтээх аргаар тоглоомын загвар хийдэг.	Цаасан хайрцаг задалж тэгш өнцөгт биетийн дэлгээсний бүтцийг тайлбарладаг.	Цаасан хайрцгийн дэлгээснээс санаа авч тэгш өнцөгт биетийн дэлгээс зурдаг.	Тэгш өнцөгт биетийг дэлгээс байгуулах аргаар бүтээдэг.	Тэгш өнцөгт биетийн дэлгээс байгуулах аргаар тоглоомын загвар хийдэг.
ДУТ4.2 ҮД5 Ш12. Хавтгай дүрсүүдийг сэтэлж хайчлах аргаар холбож 3 хэмжээст бүтээл хийдэг.	Хавтгай дүрсүүдийг сэтэлж хайчлах, холбох арга, дарааллыг бүтээлийн жишээгээр тайлбарладаг.	Хавтгай дүрсүүдийг зурж хайчлан бэлтгэдэг.	Хавтгай дүрсүүдийг зурж хайчлан, холбох хэсгүүдийн тэмдэглэн сэтэлж бэлтгэдэг.	Хавтгай дүрсүүдийг сэтэлж хайчилсан хэсгээр нь холбож 3 хэмжээст бүтээл хийдэг.

ДУТ4.2 ҮД5 Ш13. Туузан цаасыг хэлбэр үүсгэн холбох аргаар 3 хэмжээст чимэглэлийн бүтээл хийдэг.	Бүтээлийн онцлогт нийцүүлэн цаасаа сонгож туузан хэлбэр үүсгэн хайчлан бэлтгэдэг.	Туузан цаасыг хуйлж янз бүрийн хэлбэр үүсгэдэг.	Туузан цаасыг хуйлж чимэглэлийн загварын бүрдэл хэсгийг бүтээдэг.	Туузан цаасыг хэлбэр үүсгэн холбож 3 хэмжээст чимэглэлийн загвар бүтээдэг.
ДУТ4.2 ҮД6 Ш14. Төрөл бүрийн биет (хэрэглээнээс гарсан шил)-ийг байгалийн материал (будaa, чулуу, самрын яс)-ыг баримлын шаварт шигтгэх аргаар чимэглэдэг.	Төрөл бүрийн биет (хэрэглээнээс гарсан шилэн сав)-ийг шигтгэн чимэглэх материалаа (будaa, чулуу, самрын яс) сонгодог.	Төрөл бүрийн биет (хэрэглээнээс гарсан шилэн сав)-ийг баримлын шавраар бүрж бэлтгэдэг.	Байгалийн материалыг баримлын шаварт шигтгэн чимэглэх зохиомжоо төлөвлөн дүрсэлдэг.	Байгалийн материалыг баримлын шаварт шигтгэх аргаар чимэглэж бүтээл хийдэг.
ДУТ4.2 ҮД6 Ш15. Төрөл бүрийн биетийг холбох хүндрүүлэгч ачаа, харимхай металл салхины хүч ашиглан хөдөлгөөнт техникийн загвар бүтээдэг.	Техникийн загварын онцлогт нийцүүлэн төрөл бүрийн материалыг сонгодог.	Төрөл бүрийн материалаар техникийн загварын бүрдэл хэсгүүдийг хийж бэлтгэдэг.	Бүрдэл хэсгийг холбож 3 хэмжээст техникийн загвар бүтээдэг.	Хүндрүүлэгч ачаа, харимхай металл салхины хүч ашигласан техникийн хөдөлгөөнт загвар бүтээдэг.

4.2.5. Үнэлгээний нэгж 5. Ажил мэргэжил, амьдрах ухаан

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ4.2 ҮД7. Сурагч ажил мэргэжлийн онцлог болон өөртөө үйлчлэх арга барилын талаарх ойлголтоо гар оёдлоор оёх, хөнгөн зууш бэлтгэж харуулна.	ДУТ4.2 ҮД7 Ш16. Гар оёдлын багаж хэрэгслийг ашиглан хоёр бүрдэл хэсгийг (товч оёх) холбож оёж, оёдолчин мэргэжлийн онцлогийг тайлбарладаг.
		ДУТ4.2 ҮД7 Ш17. 2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зууш бэлтгэж, тогооч мэргэжлийн онцлогийг тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ4.2 ҮД7 Ш16. Гар оёдлын багаж хэрэгслийг ашиглан хоёр бүрдэл хэсгийг (товч оёх) холбож оёж, оёдолчин мэргэжлийн онцлогийг тайлбарладаг.	Гар оёдлын багаж хэрэгслийг гадаад байдлаар таньж нэрлэдэг.	Гар оёдлын багаж хэрэгслийн зориулалт, аюулгүй ажиллагааг тайлбарладаг.	Гар оёдлын багаж хэрэгслийг ажилд бэлтгэж хоёр бүрдэл (зөөлөн) хэсгийг холбож оёдог.	Гар оёдлын багаж хэрэгслээ ажилд бэлтгэн товч оёдог, оёдолчин мэргэжлийн онцлогийг тайлбарладаг.
ДУТ4.2 ҮД7 Ш17. 2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зууш бэлтгэж, тогооч мэргэжлийн онцлогийг тайлбарладаг.	2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зуушны орцыг тодорхойлдог.	2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зуушны материалыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн сонгодог.	2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зуушны материалыг аюулгүйн зааврын дагуу хэрчиж бэлтгэдэг.	2-3 төрлийн орц найрлагатай хөнгөн зуушийг эрүүл ахуйн болон өөрийн сонирхолд нийцүүлэн бэлтгэдэг, тогооч мэргэжлийн онцлогийг тайлбарладаг.

ТАВДУГААР БҮЛЭГ. V АНГИ

5.1. V АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	5.1б. Өнгийн уламжлалт нэршил, бэлгэдлийг тайлбарлах, нэг өнгийг цайруулах аргыг зураг дүрслэлдээ ашиглах 5.1в. Биетийн гэрэл сүүдрийг дүрслэхдээ цэглэх, толболох аргыг ашиглах	Дүрслэлийн хэл	ДУТ5.1 ҮД1. Сурагч зохиомжийн хэрэгслүүд (уламжлалт өнгө, цэглэх, толболох арга илэрхийлэл)-ийг таньж тодорхойлох, тэдгээрийг ашиглан зурж дүрсэлж чаддаг болно.
2	5.1г. Задгай болон өнцөглөсөн зохиомжийн ялгааг харьцуулан зураачдын бүтээлийн жишээн дээр тайлбарлах 5.1д. Юмсын хол, ойр байршлыг нэг цэгийн алслалттай холбон тайлбарлах 5.1е. Юмсын хол, ойр байршлыг хүйтэн дулаан өнгө, хүнд хөнгөн өнгийн ялгаатай холбон тайлбарлах 5.1ж. Хүний нүүрний хэсгүүдийн хэмжээ, харьцааг дүрслэх аргыг зураг дүрслэлдээ ашиглах	Урлан бүтээхүй	ДУТ5.1 ҮД2. Сурагч зохиомжийн онцлог, орон зайн (нэг цэгийн болон өнгийн алслалт) болон хүн зурах аргачлалын ойлголтоо зураг дүрслэлээр илэрхийлж чаддаг болно.
3	5.1а. Дүрслэх урлагийн төрөл зүйлийг бүтээлийн жишээгээр тайлбарлах 5.1з. Гадаадын зураачдын уран зургийн бүтээлийг өөрийн бодол төсөөллөөр тайлбарлах 5.1б. Өнгийн уламжлалт нэршил, бэлгэдлийг тайлбарлах, нэг өнгийг цайруулах аргыг зураг дүрслэлдээ ашиглах 5.1и. Геометрийн дүрсийн гаралтай хээ угалзыг дүрслэх 5.1к. Түйхий ба их дагнаасын харьцуулах онцлог, ялгааг тайлбарлах 5.1л. Монгол зургийг орон зайтай дүрслэх аргыг жишээн дээр тайлбарлах	Соёлын үнэт зүйл	ДУТ5.1 ҮД3. Сурагч дүрслэх урлагийн төрөл зүйл, гадаадын болон монголын уламжлалт уран зургийн бүтээлийн онцлогийг тайлбарлах, арга аргачлалаас санаа авч зурж дүрсэлж чаддаг болно.
4	5.2а. Цаас дахин боловсруулан ашиглах талаар жишээн дээр тайлбарлах 5.2ж. Цаасан зуурмагаар баримал, шуумал хийх 5.2в. Нимгэн картон хуйлж ирмэгээр нь зөрүүлэн наах аргаар цилиндр, конус биет бүтээх 5.2г. Цилиндр, конус биетийн бүрдэл хэсгийн тоог нэмэх аргаар загварчилж бүтээл хийх 5.2б. Цаасыг нугалах, хуйлах аргаар чимэглэлийн загвар хийх 5.2д. Автомашины загварын хэлбэрийг өөрчлөх аргаар зориулалтыг тодорхойлох 5.2е. Байгалийн материал (боргоцой, чулуу)-ын хэлбэрийг ашиглан бүтээл хийх 5.2з. Цаасан тавгийн хэлбэрийг өөрчлөх аргаар малгайн загвар бүтээх	Хоёр ба гурван хэмжээст бүтээл	ДУТ5.2 ҮД4. Сурагч цаасыг дахин боловсруулж, хэрэглээнээс гарсан цаасаар 3 хэмжээст баримал, шуумал хийж чаддаг болно. ДУТ5.2 ҮД5. Сурагч цилиндр, конус биетийг бүтээх загварчлах болон цаасыг нугалах, хуйлах аргаар 3 хэмжээст бүтээл хийж чаддаг болно. ДУТ5.2 ҮД6. Сурагч төрөл бүрийн материал, биетийн хэлбэрийг өөрчлөн загварчлах болон байгалийн материал (боргоцой, чулуу)-ын хэлбэр ашиглан чимэглэх аргаар бүтээл хийж чаддаг болно.
5	5.2и. Энгийн гар оёдлын төрлүүдийг зөөлөн эдлэл хийхдээ ашиглах 5.2к. 3-4 төрлийн орц найрлагатай хачиртай талх бэлтгэх 5.2л. Сургууль дээрх ажил мэргэжлүүдийн нэрлэх онцлог болон нийтлэг талыг жишээгээр тайлбарлах	Ажил мэргэжил, амьдрах ухаан	ДУТ5.2 ҮД7. Сурагч ажил мэргэжлийн онцлог болон өөртөө үйлчлэх арга барилын талаарх ойлголтоо гар оёдлын жижиг эдлэл хийх, хөнгөн зууш бэлтгэн харуулна.

5.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

5.2.1. Үнэлгээний нэгж 1. Дүрслэлийн хэл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ5.1 ҮД1 Сурагч зохиомжийн хэрэгслүүд (уламжлалт өнгө, цэглэх, толболох арга илэрхийлэл)- ийг таньж тодорхойлох, тэдгээрийг ашиглан зурж дүрсэлдэг болно.	ДУТ5.1 ҮД1 Ш1. Улс, үндэстний өнгийн бэлгэдлийг тайлбарлах, зураг бүтээлдээ тусган дүрсэлдэг.
		ДУТ5.1 ҮД1 Ш2. Өнгийн уламжлалт нэршлийг таньж тодорхойлох, нэг өнгийг цайруулах аргаар зурж дүрсэлдэг.
		ДУТ5.1 ҮД1 Ш3. Цэглэх, толболох аргаар энгийн биетийн гэрэл сүүдрийг дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ5.1 ҮД1 Ш1. Улс, үндэстний өнгийн бэлгэдлийг тайлбарлах, зураг бүтээлдээ тусган дүрсэлдэг.	Улс, үндэстний бэлгэдэл өнгийг нэрлэдэг.	Улс, үндэстний өнгийн бэлгэдлийг харьцуулж тайлбарладаг.	Монгол үндэстний өнгийн бэлгэдлийг үндсэн өнгийн жишээн (улаан, хөх, шар, цагаан) дээр тайлбарладаг.	Монгол үндэстний өнгийн бэлгэдлийг зураг бүтээлдээ тусган дүрсэлдэг.
ДУТ5.1 ҮД1 Ш2. Өнгийн уламжлалт нэршлийг таньж тодорхойлох, нэг өнгийг цайруулах аргаар зурж дүрсэлдэг.	Өнгийг уламжлалт нэршлээр нэрлэдэг.	Өнгийн уламжлалт нэршил (эцэг, эх, хүү өнгө) онцлогийг тайлбарладаг.	Нэг өнгийг цайруулан зурвас үүсгэн зурж дүрсэлдэг.	Нэг өнгийг цайруулах аргаар орон зайн үүсгэн зураг зурдаг.
ДУТ5.1 ҮД1 Ш3. Цэглэх, толболох аргаар энгийн биетийн гэрэл сүүдрийг дүрсэлдэг.	Цэглэж, толболох гэрэл сүүдрийг дүрслэх аргыг жишээн дээр тайлбарладаг.	Энгийн биетийг зургийн хавтгайд хэв ашиглан зохиомжлон дүрсэлдэг.	Энгийн биетийн гэрэл сүүдрийг тодорхойлж, ил харагдах ирмэгийг тодруулан зурдаг.	Энгийн биетийн гэрэл сүүдрийг цэглэх, толболох аргаар зурж дүрсэлдэг.

5.2.2. Үнэлгээний нэгж 2. Урлан бүтээхүй

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ5.1 ҮД2. Сурагч зохиомжийн онцлог, орон зайн (нэг цэгийн болон өнгийн алслалт) болон хүн зурах аргачлалын ойлголтоо зураг дүрслэлээр илэрхийлнэ.	ДУТ5.1 ҮД2 Ш4. Задгай болон өнцөглөсөн зохиомжийн ялгааг харьцуулж (зураачдын бүтээлийн жишээн дээр) тайлбарлах замаар ойлголтоо зураг дүрслэлээр илэрхийлдэг.
		ДУТ5.1 ҮД2 Ш5. Юмсын хол, ойр байршлыг нэг цэгийн алслалттай холбон тайлбарлах, зураг дүрслэлээр илэрхийлдэг.
		ДУТ5.1 ҮД2 Ш6. Юмсын хол, ойр байршлыг хүйтэн дулаан өнгө, хүнд хөнгөн өнгийн ялгаатай холбон тайлбарлах, зураг дүрслэлээр илэрхийлдэг.
		ДУТ5.1 ҮД2 Ш7. Хэмжээ, харьцааг баримжаалах аргаар хүний толгой, нүүрний хэсгийг дүрслэн зурдаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ5.1 ҮД2 Ш4. Задгай болон өнцөглөсөн зохиомжийн ялгааг харьцуулж (зураачдын бүтээлийн жишээн дээр) тайлбарлах замаар ойлголтоо зураг дүрслэлээр илэрхийлдэг.	Задгай болон өнцөглөсөн зохиомжийн ялгааг бүтээлийн жишээн дээр нэрлэдэг.	Задгай болон өнцөглөсөн зохиомжийн онцлогийг бүтээлийн жишээн дээр тайлбарладаг.	Задгай болон өнцөглөсөн зохиомжийн онцлогийг дүрсэлж харьцуулан тайлбарладаг.	Задгай болон өнцөглөсөн зохиомжийн аргаар зураг зурдаг.
ДУТ5.1 ҮД2 Ш5. Юмсын хол, ойр байршлыг нэг цэгийн алслалттай холбон тайлбарлах, зураг дүрслэлээр илэрхийлдэг.	Нэг цэгийн алслалтын аргаар зурсан зургийг таньж нэрлэдэг.	Нэг цэгийн алслалтын аргыг бүтээлийн жишээн дээр тайлбарладаг.	Юмсын хол, ойр байршлыг нэг цэгийн алслалттай холбон тайлбарладаг.	Нэг цэгийн алслалтын аргаар зураг зурдаг.
ДУТ5.1 ҮД2 Ш6. Юмсын хол, ойр байршлыг хүйтэн дулаан өнгө, хүнд хөнгөн өнгийн ялгаатай холбон тайлбарлах, зураг дүрслэлээр илэрхийлдэг.	Өнгийн алслалттай зургаас юмсын хол, ойр байршлыг тодорхойлж тайлбарладаг.	Юмсын хол, ойр байршлыг хүйтэн дулаан өнгө, хүнд хөнгөн өнгийн ялгаатай холбон тайлбарладаг.	Юмсын хол, ойр байршлыг хүйтэн дулаан өнгө, хүнд хөнгөн өнгийн ялгаагаар дүрсэлж тайлбарладаг.	Өнгийн алслалтын аргаар зураг зурдаг.
ДУТ5.1 ҮД2 Ш7. Хэмжээ, харьцааг баримжаалах аргаар хүний толгой, нүүрний хэсгийг дүрслэн зурдаг.	Хүний толгой, нүүрний хэсгийг баримжаалан зурах аргыг жишээн дээр тайлбарладаг.	Зургийн хавтгайд хүний толгой, нүүрний хэсгийг баримжаалан дүрсэлдэг.	Хүний толгой, нүүрний хэсгийн эрхтнүүдийг байршлыг тодорхойлж зурдаг.	Хэмжээ, харьцааг баримжаалах аргаар хүний хөрөг зургийг зурдаг.

5.2.3. Үнэлгээний нэгж 3. Соёлын үнэт зүйл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ5.1 ҮД3. Сурагч дүрслэх урлагийн төрөл зүйл, гадаадын болон монголын уламжлалт уран зургийн бүтээлийн онцлогийг тайлбарлах, арга аргачлалаас санаа авч зурж дүрсэлнэ.	ДУТ5.1 ҮД3 Ш8. Дүрслэх урлагийн төрөл зүйлийг бүтээлийн жишээгээр тайлбарлах, санаа авч өөрийн бодол төсөөллөө дүрсэлдэг.
		ДУТ5.1 ҮД3 Ш9. Гадаадын зураачдын уран зургийг бүтээлийн жишээгээр тайлбарлах, санаа авч өөрийн бодол төсөөллөө дүрсэлдэг.
		ДУТ5.1 ҮД3 Ш10. Геометрийн дүрсийн гаралтай хээ угалзны онцлогийг тодорхойлж арга аргачлалын дагуу зурдаг.
		ДУТ5.1 ҮД3 Ш11. Түйхий ба их дагнаасын онцлог, ялгааг харьцуулах тайлбарлах, арга аргачлалаас санаа авч зурж дүрсэлдэг.
		ДУТ5.1 ҮД3 Ш12. Монгол зургийг орон зайтай дүрслэх аргыг жишээн дээр тайлбарлах, өөрийн бодол төсөөллөө дүрсэлдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ5.1 ҮД3 Ш8. Дүрслэх урлагийн төрөл зүйлийг бүтээлийн жишээгээр тайлбарлах, санаа авч өөрийн бодол төсөөллөө дүрсэлдэг.	Бүтээлийн жишээн дээр дүрслэх урлагийн төрөл зүйлийг нэрлэдэг.	Бүтээлийн жишээн дээр дүрслэх урлагийн төрөл зүйлийг тайлбарладаг.	Дүрслэх урлагийн төрөл зүйлийг харьцуулж онцлогийг тодорхойлж тайлбарладаг.	Дүрслэх урлагийн төрөл зүйлээс санаа авч өөрийн бодол төсөөллөө зурж дүрсэлдэг.
ДУТ5.1 ҮД3 Ш9. Гадаадын зураачдын уран зургийг бүтээлийн жишээгээр тайлбарлах, санаа авч өөрийн бодол төсөөллөө дүрсэлдэг.	Гадаадын зураачдын уран зургийн бүтээлийг нэрлэдэг. (сурах бичгээс сонгосон)	Уран зургийн нэр, үйл явдлыг холбон тайлбарладаг.	Уран зургийн бүтээлийн онцлогийг бүтээгдсэн цаг үе, уран бүтээлчтэй нь холбон тайлбарладаг.	Гадаадын зураачдын уран зургийг бүтээлээс санаа авч өөрийн бодол төсөөллөө зурж дүрсэлдэг.
ДУТ5.1 ҮД3 Ш10. Геометрийн дүрсийн гаралтай хээ угалзны онцлогийг тодорхойлж арга аргачлалын дагуу зурдаг.	Геометрийн дүрсийн гаралтай хээ угалзыг нэрлэдэг.	Геометрийн дүрсийн гаралтай хээ угалзны онцлогийг тодорхойлж тайлбарладаг.	Геометрийн дүрсийн гаралтай хээ угалзыг зурах арга аргачлалыг жишээгээр тайлбарладаг.	Зурах арга аргачлалын дагуу геометрийн дүрсийн гаралтай хээ угалзыг зурдаг.
ДУТ5.1 ҮД3 Ш11. Түйхий ба их дагнаасын онцлог, ялгааг харьцуулах тайлбарлах, арга аргачлалаас санаа авч зурж дүрсэлдэг.	Түйхий ба их дагнаасын ялгааг таньж нэрлэдэг.	Түйхий ба их дагнаасын харьцуулж онцлогийг тодорхойлдог.	Түйхий ба их дагнаас зурах аргыг жишээгээр тайлбарладаг.	Түйхий ба их дагнаас зурах аргаар зурж дүрсэлдэг.
ДУТ5.1 ҮД3 Ш12. Монгол зургийг орон зайтай дүрслэх аргыг жишээн дээр тайлбарлах, өөрийн бодол төсөөллөө дүрсэлдэг.	Монгол зургийн бүтээлийн дүр, дүрслэлийн тоочин нэрлэдэг.	Монгол зургийн дүр дүрслэл, орон зайн илэрхийллийн тайлбарладаг.	Монгол зургийг орон зайтай дүрслэх аргаар зурж дүрсэлдэг.	Монгол зургийн дүр дүрслэл, орон зайн илэрхийллийн аргаар өөрийн бодол төсөөллөө зурдаг.

5.2.4. Үнэлгээний нэгж 4. Хоёр ба гурван хэмжээст бүтээл

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ5.2 ҮД4. Сурагч цаасыг дахин боловсруулж, хэрэглээнээс гарсан цаасаар 3 хэмжээст баримал, шуумал хийж чаддаг болно.	ДУТ5.2 ҮД4 Ш13. Цаасыг дахин ашиглах арга аргачлалыг судлах замаар хэрэглээнээс гарсан цаасаар зуурмаг бэлтгэж баримал, шуумал хийдэг.
2	ДУТ5.2 ҮД5. Сурагч цилиндр, конус биетийг бүтээх загварчлах болон цаасыг нугалах, хуйлах аргаар 3 хэмжээст бүтээл хийдэг болно.	ДУТ5.2 ҮД5 Ш14. Нимгэн картон хуйлж ирмэгээр нь зөрүүлэн наах аргаар цилиндр, конус бүтээх бүрдэл хэсгийн тоог нэмж загварчилдаг. ДУТ5.2 ҮД5 Ш15. Цаасыг нугалах, хуйлах аргаар чимэглэлийн загвар хийдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

3	ДУТ5.2 ҮД6. Сурагч төрөл бүрийн материал, биетийн хэлбэрийг өөрчлөн загварчлах болон байгалийн материал (боргоцой, чулуу)-ын хэлбэр ашиглан чимэглэх аргаар бүтээл хийж чаддаг болно.	ДУТ5.2 ҮД6 Ш16. Төрөл бүрийн биетийн хэлбэрийг өөрчлөх аргаар автомашины загвар зохион бүтээдэг.
		ДУТ5.2 ҮД6 Ш17. Байгалийн материал (боргоцой, чулуу)-ын хэлбэрийг ашиглан бүрдэл хэсгийн тоо нэмэх аргаар бүтээл хийдэг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ5.2 ҮД4 Ш13. Цаасыг дахин ашиглах арга аргачлалыг судлах замаар хэрэглээнээс гарсан цаасаар зуурмаг бэлтгэж баримал, шуумал хийдэг.	Цаас дахин боловсруулан ашиглах үйлдвэрлэлийн үйл явцыг жишээн дээр тайлбарладаг.	Цаасыг дахин ашиглах технологийн дагуу хэрэглээнээс гарсан цаасаар зуурмаг бэлтгэдэг.	Цаасан зуурмагаар хэв ашиглан технологийн дагуу янз бүрийн хэлбэр бүтээдэг.	Цаасан зуурмагаар технологийн дагуу баримал шуумал хийдэг.
ДУТ5.2 ҮД5 Ш14. Нимгэн картон хуйлж ирмэгээр нь зөрүүлэн наах аргаар цилиндр, конус бүтээх бүрдэл хэсгийн тоог нэмж загварчилдаг.	Цилиндр, конус биетийн таньж нэрлэдэг.	Цилиндр, конус биетийг бүтээх хялбар аргыг туршиж тайлбарладаг.	Хатуу цаас хуйлж наах аргаар цилиндр, конус биет бүтээдэг.	Цилиндр, конус биетийн бүрдэл хэсгийг тоог нэмж загварчлах аргаар бүтээл хийдэг.
ДУТ5.2 ҮД5 Ш15. Цаасыг хуйлах, нугалах аргаар чимэглэлийн загвар хийдэг.	Цаасыг хуйлах, нугалах аргаар хийсэн чимэглэлийн загварын хийх аргыг тайлбарладаг.	Цаасыг нугалах, хуйлах аргаар чимэглэлийн загварын бүрдэл хэсгүүдийг хийдэг.	Бүрдэл хэсгүүдийг холбож чимэглэлийн загвараа хийдэг.	Чимэглэлийн загварын бүрдэл хэсгийг нэмэх, хасах аргаар загварчилж шинэ загвар бүтээдэг.
ДУТ5.2 ҮД6 Ш16. Төрөл бүрийн биетийн хэлбэрийг өөрчлөх аргаар автомашины загвар зохион бүтээдэг.	Автомашины загварын бүрдэл хэсгийг нэрлэдэг.	Хийх автомашины загварын онцлогт нийцүүлэн төрөл бүрийн биетийг сонгодог.	Төрөл бүрийн биетийн хэлбэрийг өөрчлөх аргаар автомашины хөдөлгөөнт загвар бүтээдэг.	Автомашины загварын хөдөлгөөн, ажиллагааг туршиж сайжруулдаг.
ДУТ5.2 ҮД6 Ш17. Байгалийн материал (боргоцой, чулуу)-ын хэлбэрийг ашиглан бүрдэл хэсгийн тоо нэмэх аргаар бүтээл хийдэг.	3 хэмжээст бүтээлийн онцлогт тохируулан байгалийн материал (боргоцой, чулуу)-ыг сонгодог.	Байгалийн материал (боргоцой, чулуу)-ын хэлбэрийг ажиглаж 3 хэмжээст бүтээлийн санааг тодорхойлдог.	Байгалийн материал (боргоцой, чулуу)-ыг холбож янз бүрийн, биет хэлбэр бүтээдэг.	Байгалийн материал (боргоцой, чулуу)-аар бүрдэл хэсгийн тоо нэмэх аргаар 3 хэмжээст бүтээл хийдэг.

4.2.5. Үнэлгээний нэгж 5. Ажил мэргэжил, амьдрах ухаан

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	ДУТ5.2 ҮД7. Сурагч ажил мэргэжлийн онцлог болон өөртөө үйлчлэх арга барилын талаарх ойлголтоо гар оёдлын жижиг эдлэл хийх, хөнгөн зууш бэлтгэн харуулна.	ДУТ5.2 ҮД7 Ш18. Энгийн гар оёдлын төрлүүдийг судлах замаар жижиг эдлэл хийдэг.
		ДУТ5.2 ҮД7 Ш19. 3-4 төрлийн орц найрлагатай хачиртай талх бэлтгэдэг.
		ДУТ5.2 ҮД7 Ш20. Сургууль дээрх ажил мэргэжлүүдийн нэрлэх онцлог болон нийтлэг талыг жишээгээр тайлбарладаг.

Гүйцэтгэлийн түвшин

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
ДУТ5.2 ҮД7 Ш18. Энгийн гар оёдлын төрлүүдийг судлах замаар жижиг эдлэл хийдэг.	Энгийн гар оёдлын төрлүүдийг ялган таньж нэрлэдэг.	Энгийн гар оёдлын төрлийг зургаар илэрхийлж хэрэглээг тайлбарладаг.	Энгийн гар оёдлын төрлүүдийг технологийн дагуу оёдог.	Энгийн гар оёдлын төрлүүдийг ашиглан жижиг эдлэл хийдэг.
ДУТ5.2 ҮД7 Ш19. 3-4 төрлийн орц найрлагатай хачиртай талх бэлтгэдэг.	3-4 төрлийн орц найрлагатай хөнгөн зуушны орцыг тодорхойлдог.	3-4 төрлийн орц найрлагатай хөнгөн зуушны материалыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн сонгодог.	3-4 төрлийн орц найрлагатай хөнгөн зуушны материалыг аюулгүйн зааврын дагуу зүсэж бэлтгэдэг.	3-4 төрлийн орц найрлагатай хөнгөн зуушийг эрүүл ахуйн болон өөрийн сонирхолд нийцүүлэн бэлтгэдэг.
ДУТ5.2 ҮД7 Ш20. Сургууль дээрх ажил мэргэжлүүдийн нэрлэх онцлог болон нийтлэг талыг жишээгээр тайлбарладаг.	Сургууль дээрх ажил мэргэжлүүдийг нэрлэдэг.	Сургууль дээрх ажил мэргэжлүүдийг онцлогийг тайлбарладаг.	Ажил болон мэргэжлийн ялгааг жишээн дээр тайлбарладаг.	Сургууль дээрх ажил болон мэргэжлийн онцлог болон нийтлэг талыг тодорхойлж тайлбарладаг.

“ЕБС-ийн Бага боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-ыг боловсруулсан ажлын хэсэг:

Математик

А.Гантуул	МУБИС, БС-ийн багш, доктор (Ph.D)
Б.Болортуяа	“Хаан Эрдэм” сургуулийн сургалтын менежер
О.Наранчимэг	“Шинэ Монгол Харүмафүжи” сургуулийн багш, тэргүүлэх
Д.Мөнх-Өлзий	“Сингафур” сургуулийн багш, заах аргач

Монгол хэл

Ш.Оюунцэцэг	БМДИ-ийн зөвлөх багш
П.Одсүрэн	БМДИ-ийн арга зүйч, доктор (Ph.D.)
Д.Ганчимэг	БХ, Бага боловсролын хөтөлбөрийн судалгаа хариуцсан мэргэжилтэн, магистр

Хүн ба Орчин, Хүн ба Байгаль

Э.Даваахүү	“Суралцахуйн баясгалан” сургалт, судалгааны төвийн захирал, магистр
Д.Чанцалдулам	“Шинэ Монгол Харүмафүжи” сургуулийн багш
З.Лхагвадулам	24 дүгээр сургуулийн багш

Хүн нийгэм

У.Туяа	Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч, доктор (Ph.D)
Д.Янжинжав	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Дүрслэх урлаг, технологи

С.Отгонтуяа	Боловсролын хүрээлэн, ЭША, магистр
Ч.Алтанчимэг	20 дугаар сургуулийн багш, зөвлөх
Б.Мөнхтуяа	“Амгалан” цогцолбор сургуулийн багш, магистр
С.Цолмон	“Шинэ эхлэл” сургуулийн багш, зөвлөх
Ж.Энхбаатар	“Шинэ зуун билэг” сургуулийн багш, зөвлөх

Эрүүл мэнд

Ч.Байгалмаа	МУБИС, БСС-ийн багш, доктор (Ph.D)
Б.Болорцэцэг	Нийслэлийн ЕБ-ын 1 дүгээр сургуулийн багш, зөвлөх
Ц.Дийдэрмаа	Нийслэлийн ЕБ-ын 47 дугаар сургуулийн багш, зөвлөх

Хөндлөнгийн шинжээч:

Д.Түмэнбаяр	МУИС. ШУС-ийн математикийн тэнхимийн багш, доктор (Ph.D)
Ө.Цэндсүрэн	Монгол улсын гавьяат багш
С.Түмэндэлгэр	МУБИС, НХУС, Нийгмийн ухааны тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор
Д.Хөхөө	МУБИС-ийн ДУТС-ийн зөвлөх багш, доктор (Ph.D)
Э.Мөнгөнтулга	МУБИС-ийн МБУС-ийн багш

Техникийн редактор:

Г. Дэлгэрмаа	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, доктор (Ph.D)
Т.Отгон-Эрдэнэ	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

Э.Сансартуяа	"Хас дизайн пресс" ХХК-ийн дизайнер
Л.Алтансүх	Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн

Энэхүү номын цахим хувилбар нь www.eec.mn вэб сайтад байршсан болно.



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Энхтайваны өргөн чөлөө, Арслантай гүүр
“ОЮУНЫ УНДРАА” группийн байр

Утас: 70119498, 70118485
И-мэйл: info@eecs.mn